



## Гүйцэтгэлийн аудитын тайлан

**ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД  
ТАВИХ ХЯНАЛТЫН ХЭРЭГЖИЛТ ҮР ДҮНГҮЙ БАЙНА.**

2020 оны 10 дугаар сар

**АУДИТЫН СЭДЭВ: ТӨРӨӨС БҮХ НИЙТИЙН  
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛ ОЛГОЖ БУЙ  
ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ҮР ДҮН**

Хүснэгтийн товъёг.....	5
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл.....	6
<i>А.1 Хууль тогтоомж эрх зүйн зохицуулалт, бодлого, хөтөлбөр хэрэгцээ шаардлагыг хангасан байна.</i> .....	8
<i>А.1.1 Мөрдөгдөж буй хууль, дүрэм журам, хэрэгцээ шаардлагыг хангаж, харилцан уялдаатай байгаа ч зарим зохицуулалт давхардаж байна.</i> .....	8
<i>А.1.2 Салбарын яамны бодлого хөтөлбөртэй орон нутгийн зарим дэд хөтөлбөрүүдийн агуулга давхардсан байна.</i> .....	12
<i>А.2 Сургалтын хэрэгцээ шаардлага болон мэргэжлийн боловсон хүчин бүрэн хангагдсан, хүртээмжтэй материаллаг орчныг бүрдүүлсэн байна.</i> .	14
<i>А.2.1 Хамран сургалтын тэгш, хүртээмжтэй орчныг бүрдүүлсэн байна.</i> .....	14
<i>А.2.2 Ерөнхий боловсролыг олгоход шаардагдах хэвийн, аюулгүй материаллаг орчин, нөхцөл бүрдсэн байна.</i> .....	15
<i>А.2.3 Зарим мэргэжлийн багшийн эрэлт хэрэгцээ их байна.</i> .....	17
<i>А.3 Ерөнхий боловсролын үйл ажиллагааны санхүүжилт бодитой төлөвлөгдөн ихэнх зардлыг зориулалтын дагуу зарцуулж байна.</i> .....	21
<i>А.3.1 Төсвийг бодитой төлөвлөж, хүүхдийн тоотой уялдуулан хуваарилсан байна.</i> .....	21
<i>А.3.2 Санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулж байгаа боловч үдийн цай хөтөлбөрийн зарцуулалт хангалтгүй байна.</i> .....	22
<b>БҮЛЭГ 2. Ерөнхий боловсрол олгох үйлчилгээний зорилго, зорилтын хэрэгжилт хангагдаж байгаа ч үйл ажиллагаанд тавих хяналт хангалтгүй байна.</b> 27	
<i>Б.1 Ерөнхий боловсролыг хөтөлбөрийн дагуу олгож байгаа боловч, сургалтын чанарын үнэлгээг бодитой хийгээгүй байна.</i> .....	27
<i>Б.1.1 Хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу бүх нийтийн ерөнхий боловсролыг эзэмшүүлж байна.</i> .....	27
<i>Б.1.2 Ерөнхий боловсролын сургалтын чанарын үнэлгээг бодитой гаргасан боловч, бүрэн хамруулж чадахгүй байна.</i> .....	31
<i>Б.2 Бүх нийтийн ерөнхий боловсрол олгох үйлчилгээнд тавих хяналтын хэрэгжилт хангалтгүй, үр дүнг тооцоогүй байна.</i> .....	32
<i>Б.2.1 Ерөнхий боловсрол олгох үйлчилгээнд тавих үе шатны хяналт хангалтгүй, үр дүнг тооцож ажиллаагүй байна.</i> .....	32
<i>Б.2.2 ЕБ олгох үйл ажиллагаанд тавих хөндлөнгийн хяналтын хэрэгжилт хангалтгүй байна.</i> .....	34
Холбогдох байгууллагын санал: .....	367
Саналд өгсөн тайлбар: .....	388

**ДҮГНЭЛТ: 39**

**ЗӨВЛӨМЖ: .....Error! Bookmark not defined.0**  
**ХАВСРАЛТУУД:.....Error! Bookmark not defined.2**

### Товчилсон үгийн тайлбар

ААН	Аж ахуйн нэгж
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
БСУГ	Боловсрол,Соёл,Урлагийн газар
БСШУ	Боловсрол Соёл Шинжлэх Ухаан
БСШУС	Боловсрол Соёл Шинжлэх Ухаан Спорт
БМДИ	Багшийн мэргэжил дээшлүүлэх институт
БНХАУ	Бүгд найрамдах хятад ард улс
ГАГ	Гүйцэтгэлийн аудитын газар
ГХБХБГ	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар
ГА	Гүйцэтгэлийн аудит
ГСЕБС	Гүнзгий сургалттай ерөнхий боловсролын сургууль
ДЗМОУБ	Дэлхийн зөн монгол олон улсын байгууллага
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЕББГ	Ерөнхий боловсролын бодлогын газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МУ	Монгол улс
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
МСҮТ	Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв
ОУ	Олон улс
ЦБСЦ	Цэцэрлэг бага сургуулийн цогцолбор
ЭЕШ	Элсэлтийн ерөнхий шалгалт

**Хүснэгтийн товьёг**

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Багшлах эрхгүй багш нарын жагсаалт	19-20
Хүснэгт 2	2017-2019 оны төсвийн төлөвлөлтийн харьцуулалт	21
Хүснэгт 3	2016-2019 оны дотуур байрны хувьсах зардал нормативаар	22
Хүснэгт 4	2016-2019 оны дотуур байрны хүүхдийн хоолны зардлын төлөвлөлт, гүйцэтгэл	23
Хүснэгт 5	Хүнсний тайлангаарх материалын үлдээгдэл	23
Хүснэгт 6	2016-2019 оны ном хэвлэлийн зардлын санхүүжилт	24
Хүснэгт 7	2016-2019 оны үдийн цайны санхүүжилт	25
Хүснэгт 8	Үдийн цайны материалын үлдээгдэл	25
Хүснэгт 9	2016-2019 оны төсөл хөтөлбөрийн санхүүжилт	26
Хүснэгт 10	Аймаг болон лаборатори сургуулийн дундаж үнэлгээ	28
Хүснэгт 11	Лаборатори Мэргэд сургуулийн сургалтын орчин	29
Хүснэгт 12	БСУГ-аас авсан мэргэжлийн онол, стандарт хангалтын дүн	33

**Зургийн товьёг**

№	Тайлбар	Хуудасны дугаар
Зураг 1	Хархорин сумын ЕБ-ын 2 дугаар сургуулийн төслийн хэрэгжилт	26-27

**Дүрслэлийн товьёг**


№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	Аймгийн төвийн сургуулиудын анги дүүргэлт	15
Дүрслэл 2	Багшийн эрэлт хэрэгцээний судалгаа	21
Дүрслэл 3	Улсын төрөлжсөн олимпиадын амжилт /аймгийн хэмжээнд/	28
Дүрслэл 4	Аймгийн ЭЕШ-ын дундаж оноо	29
Дүрслэл 5	Лаборатори Мэргэд сургуулийн сургалтын чанар /2016-2019 он/	29
Дүрслэл 6	Лаборатори Мэргэд сургуулийн төрөлжсөн олимпиадын амжилт	30
Дүрслэл 7	Лаборатори Мэргэд сургуулийн ЭЕШ-ын дундаж оноо /2016-2019 он/	30
Дүрслэл 8	Аймгийн болон лаборатори Мэргэд сургуулийн ЭЕШ-ын харьцуулалт	31

**Хавсралтын товьёг**

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хавсралт 1	Сургуулиудын 2016, 2018, 2019 онуудын үдийн цай хөтөлбөрийн гүйцэтгэл хүүхэд өдрийн зарцуулалтаар	25

<p><b>Аудит хийх үндэслэл, бүрэн эрх</b></p>	<p><b>Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл</b></p> <p>Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/53 дугаар тушаалын дагуу “Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсрол олгож байгаа өнөөгийн байдал, үр дүн”-д Төрийн аудитын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд хийв.</p>
<p><b>Аудитын зорилт</b></p>	<p>“Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсрол олгож байгаа өнөөгийн байдал, үр дүн”-д улсын хэмжээнд нэгдсэн удирдамжаар аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, Улсын Их Хурал болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэв.</p> <p>Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэв. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>➤ Ерөнхий боловсрол олгож буй өнөөгийн нөхцөл хэрэгцээ шаардлагад нийцэж байгаа эсэх;</li> <li>➤ Ерөнхий боловсрол олгох үйлчилгээний зорилго, зорилт хангагдаж байгаа эсэх;</li> </ul>
<p><b>Аудитын хамарсан хүрээ</b></p>	<p>Аудитыг Арвайхээр, Хархорин, Уянга, Бат-өлзий, Хужирт, Төгрөг, Гучин-Ус, Богд, Баруунбаян-Улаан, Нарийнтээл, Хайрхандулаан зэрэг сумд, МХГазар, ГХБХБГазар, Статистикийн хэлтэс, БСУГазар, төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуулиудын 2016-2019 оны үйл ажиллагааг /сүүлийн 3 хичээлийн жил/ хамруулан гүйцэтгэлээ.</p>
<p><b>Аудитын хязгаарлалт</b></p>	<p>.....</p>
<p><b>Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт</b></p>	<p>Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 300, 3000-3100 үндэслэн боловсруулсан Гүйцэтгэлийн аудитын журамд заасан арга зүйг ашиглан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийг мөрдлөг болгон аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга авах, ББС-ийн захирал, сургалтын менежерийн баримт бичиг, санхүүгийн тайлан, бусад шаардлагатай баримт материал, сүүлийн 4 жилийн байдлаарх үндсэн үзүүлэлтийн судалгаанд тулгуурлан дүн шинжилгээ хийж, аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.</p>
<p><b>Аудитын бүрэлдэхүүн, хугацаа</b></p>	<p>Аудитыг гүйцэтгэхдээ: Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан ГАГ-2020/10-ГА аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийг мөрдөж ажиллав. Төрийн хяналт, шалгалтын стандарт, Гүйцэтгэлийн аудитын журамд заасны дагуу аудитын дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох бусад мэдээллийг ажлын баримт материалд хавсаргав. Аудитыг Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газрын гүйцэтгэлийн аудитын аудитор С.Шийлэгмаа, аудитор П.Норпил, Нийцлийн аудитын аудитор Э.Энхбаяр нар 2019 оны 09 дугаар сарын 07-оос 11 дүгээр сарын 01-ны өдрүүдэд хийж гүйцэтгэв.</p> <p>Аудитаар 1 акт, 3 албан шаардлага, 12 зөвлөмж өгч, 19.8 сая төгрөгт үр өгөөж тооцсон.</p>

**Хүндрэл бэрхшээл** .....



## **БҮЛЭГ 1. Ерөнхий боловсрол олгож буй өнөөгийн нөхцөл хэрэгцээ шаардлагад нийцэж байна.**

### **А.1 Хууль тогтоомж эрх зүйн зохицуулалт, бодлого, хөтөлбөр хэрэгцээ шаардлагыг хангасан байна.**

#### **А.1.1 Мөрдөгдөж буй хууль, дүрэм журам, хэрэгцээ шаардлагыг хангаж, харилцан уялдаатай байгаа ч зарим зохицуулалт давхардаж байна.**

- Хуульд заасан дүрэм, журам, норм нормативыг баталсан байна.

Салбарын хуулиудад баталж мөрдүүлэхээр заагдсан норм, норматив, дүрэм, журмыг батлан мөрдүүлсэн байна. Багшийн хөгжлийг дэмжих тухай 2018 онд баталсан хуулийн 6 дугаар зүйлд заасан багшийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийг Засгийн газраас батлан мөрдүүлэх ажлыг зохион байгуулаагүй байна.

- Мөрдөгдөж буй эрх зүйн баримт бичгийг өнөөгийн хэрэгцээ шаардлагад нийцүүлж шинэчилсэн боловч зарим хуульд зохицуулалтын давхардал бий болсон байна.

Боловсролын тухай хуулийг 2002 оны 05 дугаар сарын 03-ны өдөр баталж, мөн оны 06 дугаар сарын 03-ны өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн байна. Тус хууль хэрэгжсэнээс хойш нийт 26 удаа нэмэлт, өөрчлөлт оруулжээ. Үүнээс аудитын хамрах хүрээний хугацаанд дээрх хуульд нийт 8 удаагийн нэмэлт өөрчлөлт орсон байна. Боловсролын тухай хуульд 2016 онд нэмэлт өөрчлөлт орж цөм хөтөлбөр батлагдан 2016-2017 оны хичээлийн жилээс хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой эрх зүйн хэм хэмжээний актуудад өөрчлөлт оржээ. Хуульд орсон зарим өөрчлөлтөөс онцолбол:

#### **2016 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн хуулийн нэмэлт өөрчлөлтөөр.**

- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн суралцах эрхийн хэрэгжилтийг боловсронгуй болгох зорилгоор хуульд шинээр заалт нэмжээ. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг 2016 оны 02 дугаар сарын 05-ны өдөр баталж, хуулийн 4 дүгээр бүлэгт сурч боловсрох эрхийн зохицуулалтыг нарийвчлан тусгасан байна.

#### **2016 оны 04 дүгээр сарын 14-ны өдрийн хуулийн нэмэлт өөрчлөлтөөр:**

- Цөм хөтөлбөрийг сургалтын үйл ажиллагаанд шинээр баталж нэвтрүүлэх.
- Насан туршийн тасралтгүй боловсролын үйл ажиллагааг дэмжих.
- Багшийн мэргэжил, ур чадвараа дээшлүүлэх сургалтын үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох.
- Боловсролын байгууллагын хяналттай холбоотой 3 зүйл, 12 хэсэгт нэмэлт зохицуулалтыг оруулсан
- Хуулийн нэршлийг шинээр батлагдсан эрх зүйн актуудад нийцүүлэн шинэчилсэн байна.

#### **2016 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн хуулийн нэмэлт өөрчлөлтөөр:**

- Сургуулийн удирдах зөвлөлийн үйл ажиллагаатай холбоотойгоор удирдах зөвлөлийн гишүүдийг томилох болон чөлөөлөх зохицуулалтыг шинээр нэмж оруулсан

#### **2017 оны 12 дугаар сарын 21-ны өдрийн хуулийн нэмэлт өөрчлөлтөөр:**

- Хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсгийн хүчингүй болсонд тооцсон / сургалтын стандартыг боловсруулж Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хуулийн дагуу батлуулж, улсын бүртгэлд бүртгэх талаар /



## 2018 оны 06 дугаар сарын 21-ны өдрийн хуулийн нэмэлт өөрчлөлтөөр:

- Аймгийн БСУГ-ийн сонгон шалгаруулалтын дүнг үндэслэн ЕБС-ын захирал, цэцэрлэгийн эрхлэгчийг томилох тэдгээрийн үр дүнгийн гэрээний хэрэгжилт болон БСУГ-ийн саналыг үндэслэн чөлөөлөх эрх нь сумын Засаг даргын бүрэн эрхэд шилжсэн гэх зэргээр боловсролын салбарын голлох хуульд өөрчлөлт оруулжээ.

Бага, дунд боловсролын тухай хууль нь 2002 оноос батлагдан хэрэгжиж эхэлсэн бөгөөд нийт 13 удаагийн хуулиар нэмэлт өөрчлөлт орсон байна. “Цөм” хөтөлбөр хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор уг хуулийн холбогдох зүйл заалтад нэмэлт өөрчлөлт орж бага болон дунд боловсролын агуулгад хүүхдийн хүчирхийллийн асуудлыг шийдвэрлэх арга замыг багшийн үүрэгтэй уялдуулан зохицуулсан байна.

Дээрх хуулийн 2018 оны нэмэлт өөрчлөлтөөр сургуулийн барилга байгууламж дахь хоол үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалттай байр, талбай, түүний тоног төхөөрөмжийг ашиглах, эзэмших, захиран зарцуулахтай холбоотой журамд заасны дагуу түрээслүүлэх асуудлыг захирлын эрхийн асуудал болгон зохицуулсан бөгөөд 2019 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн хуулиар уг зохицуулалтыг хүчингүйд тооцсон байна. Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хууль 2019 оны 5 дугаар сард батлагдсан бөгөөд 2020-2021 оны хичээлийн жилээс эхэлж мөрдөгдөж байна. Хуулиар ЕБС-д сурч байгаа болон дотуур байранд амьдарч байгаа хүүхдийн хоол үйлдвэрлэлтэй холбоотой харилцааг зохицуулжээ.

Хоол үйлдвэрлэлийн үйл ажиллагааг эрхлэхдээ бүх сурагчдыг хамруулан сургуулийн нөөц бололцоонд тулгуурлан стандарт, техникийн зохицуулалтад нийцсэн байр, тоног төхөөрөмжийг ашиглан хүний нөөцийг зүй зохистой байгуулахаар зохион байгуулж байна. Энэхүү хуулийн үйлчлэлийн хүрээнд орон нутагт ажлын байр нэмэгдэх болон орон нутагт хүнсний чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгчдийг дэмжих, үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих, сурагчид эрүүл ахуйн шаардлага хангасан хоол хүнсээр хангагдах боломж бүрдэж бүрдүүлэхээр ажиллаж байна.

Бага, дунд боловсролын тухай хуульд 2016 оны 02 дугаар сарын 05-ны өдөр нэмэлт өөрчлөлтөөр орсон 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсгийн заалт нь давхардсан байна. Давхардсан 2 заалт нь өөр өөр зохицуулалттай байгаа бөгөөд эхний 13.3 дахь хэсэг нь 2006 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан, дараагийн 13.3 дахь хэсэг нь 2016 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар нэмэгджээ. Хуулийн заалтын давхардлаас шалтгаалан хуулийг буруу хэрэглэх, эсвэл давхардуулах, эрх зүйн баримт бичгийн стандартаас гажих зэрэг сөрөг үр дагавруудыг үүсгэх эрсдэл байна.

Багшийн хөгжлийг дэмжих тухай хууль нь 2018 онд батлагдаж 2019-2020 оны хичээлийн жилээс хэрэгжиж эхэлжээ. Бага, дунд боловсролын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 “Багш нь багшлах эрхтэй байна” гэж заасны дагуу ЕБ-ын сургуулийн багш нь заавал багшлах эрхийн баталгаажсан үнэмлэхтэй байх шаардлага тавигдаж байна. Гэтэл Багшийн хөгжлийн дэмжих тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5 “Багш мэргэжлээр дээд боловсрол эзэмшсэн төгсөгч нь багшлах эрхтэй байна”-гэж заасан нь 2019 оноос хойш их, дээд сургуулийг багш мэргэжлээр төгссөн багш нарт хамаарч байна.

Засгийн газрын 2012 оны 180 дугаар тогтоолын дагуу Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийг байгуулжээ. Багшийн мэргэжил дээшлүүлэх институт нь жил болгон улсын хэмжээнд зохион байгуулагддаг Үндсэн сургалтын / 1, 5, 10 дахь жилийн / үйл ажиллагаа нь Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулийн холбогдох зүйл заалттай зөрчилдөх эрсдэл бий болжээ. Энэ нь байгууллагын дүрмийн 2 дугаар зүйлийн 2.2.17 “багшлах эрх болон мэргэжлийн зэрэг олгох ажлыг зохион байгуулах”-д заасны дагуу заавал багшлах эрхийг олгох үүрэгтэй болж байгаа юм. Эрх зүйн зохицуулалтын хувьд харилцан уялдаагүй байсны улмаас Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулийн шинэ зохицуулалт нь өмнөх онуудад хэрэгжиж байсан үүргийн харилцааг үгүйсгэж байна.

Мөн Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 “Багш мэргэжлээр их, дээд сургууль төгсөөгүй дээд боловсролтой төгсөгчид багшлах эрх олгох, сунгах шалгалтыг зохион байгуулна” гэж зааснаар багш бус өөр мэргэжлийн төгсөгч шалгалт өгч багшлах эрхтэй болох зохицуулалттай болжээ. Үүнээс гадна Бага, дунд боловсролын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 “Ерөнхий боловсролын сургуулийн багшийг багш бэлтгэдэг их сургууль, дээд сургууль, коллежид бэлтгэнэ” гэж заавал багшийн сургуулийг багш мэргэжлээр төгссөн байхаар заасан байгаа нь Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь заалттай зөрчилдөж байна.

Бага, дунд боловсролын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3 “Багш бус мэргэжлийн хүн заах арга зүйн сургалтад хамрагдсаны дараа багшлах эрх авна” гэсэн нь багшийн мэргэжлийг эзэмшээгүй төгсөгч заах арга зүйн ямар сургалтад ямар хугацаагаар суралцах талаар нарийвчлан тусгаагүй байна. Нөгөө талаар өөр чиглэлээр мэргэжил эзэмшсэн төгсөгч нь заах арга зүйн сургалтад хамрагдсаны үндсэн дээр сургуульд багшлах нь сурагчдын боловсролын чанар, эзэмшвэл зохих мэдлэгийг бүрэн гүйцэд олгож чадах эсэхэд эргэлзээ төрүүлэхээр байна.

- *Холбогдох дүрэм, журам, норм норматив, стандартыг бүрэн боловсруулан баталжээ.*

БСШУ-ны сайдын 2016 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн А/275 дугаар тушаалаар сургалтын төлөвлөгөөний дагуу ахлах ангийн сургалтын талаар баримтлах бодлогыг шинэчлэн баталжээ. Энэ тушаалаар ахлах ангийн сургалтын төлөвлөгөөг 2016-2017 оны хичээлийн жилээс эхлэн ЕБ-ын сургуулийн 10 дугаар ангид, 2017-2018 оны хичээлийн жилээс 11 дүгээр ангид, 2018-2019 оны хичээлийн жилээс 12 дугаар ангид тус тус хэрэгжүүлэхээр төлөвлөн баталсан байна.

Дээрх тушаалын зарим зохицуулалтыг шинэчлэн “Цөм хөтөлбөр”-ийн хүрээнд ахлах ангиудад заавал судлах хичээл тус бүр дээр нарийвчилсан зохицуулалтыг БСШУ-ны сайдын 2016 оны 06 дугаар сарын 27-ны А/277 дугаар тушаалаар шинэчилсэн байна.

БСШУ-ны сайдын 2016 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 05 дугаар албан даалгавраар Бүрэн дунд боловсролын сургалтын “Цөм хөтөлбөр”-ийг үндэсний хэмжээнд хэрэгжүүлж, 2016-2017 оны хичээлийн жилээс эхлэн чанарын шинэчлэлийг эрчимжүүлэн, чанартай боловсролын үйлчилгээ үзүүлэхийг зорьсон байна.

БСШУС-ын сайдын 2019 оны 08 дугаар сарын 01-ны өдрийн А/492 дугаар тушаалаар 2016 онд батлан мөрдөгдөж байсан “Цөм хөтөлбөр”-ийн агуулга, хэрэгжих болон хамрах хүрээг шинэчлэн сайжруулсан хэвлэл болгон баталжээ.

Тус шинэчилсэн “Цөм хөтөлбөр”-ийн агуулгын хүрээнд бага анги, суурь боловсрол, бүрэн дунд боловсролын заавал судлах судлагдахуун тус бүрийг боловсронгуй болгон үнэлгээний түвшинтэй уялдуулан хэрэгжүүлж эхэлжээ. Уг тушаал хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан 2015, 2016 онуудад батлагдсан “Цөм хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх салбарын сайдын тушаалууд хүчингүй болжээ.

Аудитын хамрах хүрээнд мөрдөгдөж байсан эрх зүйн баримт бичгийг өнөөгийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн шинэчилж, “Цөм хөтөлбөр”-ийн агуулга болон хэрэгжилтийг үнэлэх үнэлгээний систем нь өнөөгийн байдалд нийцсэн гэж дүгнэж байна.

Шинээр баталж сайжруулсан “Цөм хөтөлбөр” нь агуулгын давхардлыг арилгах, залгамж холбоог тодорхой болгох, хүндрэлийг арилгах, суралцах үйлийн тоог цөөлж багтаамжийг багасган чанарыг эрхэмлэх, суралцагчийн эзэмших мэдлэг чадварын илэрхийлэл болсон суралцахуйн зорилтын томъёоллыг онол арга зүйд нийцүүлэн засах, шинээр томъёолох зэргээр сайжирсан байна. Гэхдээ сүүлийн 4 жилийн хугацаанд сургалтын “Цөм хөтөлбөр” батлагдаж 1 удаа шинэчлэгдсэн, хөтөлбөр хэрэгжиж эхэлснээс хойш голлох Боловсролын тухай, Бага, дунд боловсролын тухай хуулиудад 2016 оноос хойш нийт 15 удаагийн нэмэлт өөрчлөлт орж, хуулийг дагасан дүрэм, журмуудад олон удаа өөрчлөгджээ. Засгийн газар болон салбарын сайдын 59 удаагийн тогтоол, тушаал 2019-2020 онуудад шинээр өөрчлөгдөн батлагдсан байна.

Ийнхүү эрх зүйн баримт бичгүүд, сургалтын хөтөлбөр, сургалтын төлөвлөгөө, сурах бичиг, суралцахуйн үр дүнг үнэлэх үнэлгээний журам зэрэг нь ойр ойрхон өөрчлөгдөж байгаа нь сургууль багш нарын үйл ажиллагааны тогтвортой байдлыг алдагдуулахад хүргэж, анги танхим дахь хичээлийн үр өгөөжийг бууруулж байна.

БСШУ-ы сайдын 2013 оны А/309 тоот тушаалаар батлан мөрдөгдөж байсан ЕБС-ийн суралцагчийн болон сургалтын чанарын үнэлгээний журмыг 2018 оны А/425 тоот тушаалаар шинэчлэн найруулжээ. Уг тушаалын гол агуулга нь суралцагчийн эзэмшсэн мэдлэг чадварын бодит ахиц, төлөвшил, хандлагын өөрчлөлтийг тооцох, сургууль болон багшийн үйл ажиллагааг суралцагчидтай нягт уялдуулан сургалтын чанар, үр дүнг сайжруулахад чиглэгдсэн байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой 2018 оны БСШУС-ын сайдын А/155 дугаар тушаалаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний үлгэрчилсэн загварыг, төлөвлөгөө боловсруулах аргачлалын хамтаар баталсан байна. 2019 оны А/292 дугаар тоот тушаалаар ЕБС-д суралцаж буй хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдыг тусгай анги танхимд, тусгай хэрэгцээт боловсролын багш мэргэжилтнээр хичээл заалгах, хөгжлийг дэмжих танхимд байвал зохих хэрэглэгдэхүүн, тусгай хэрэгслийн жагсаалтыг баталжээ.

БСШУС-ын сайдын 2018 оны А/460 тоот тушаалаар багшийн журналын загварыг өөрчлөн 2018-2019 оны хичээлийн жилээс эхлэн цаасан хэвлэмэл багшийн журналыг

сургалтад хэрэглэж байна. Тус оны хичээлийн жил дууссаны дараагаар буюу 2019 оны А/499 дугаар тушаалаар ЕБ-ын сургалтад цахим журнал хөтлөх талаар эрх зүйн зохицуулалт хийгджээ. Журмын 4-т зааснаар цахим журналыг боловсролын салбарын удирдлагын мэдээллийн системээр хөтлөх, хэвлэмэл журналыг давхардуулан хөтлөхгүй байх арга хэмжээ авахыг сургуулийн захирлуудад үүрэг болгосон байна. Энэ талаар аймгийн БСУГ-аас тодруулахад тухайн тушаалын хэрэгжилт нь цахим журнал хөтлөх хүсэлтэй байгаа сургуулиуд болон сургуулийн зарим ангиуд зохион байгуулж ажилласан байна.

Аудитын явцад хэрэгжиж буй цахим журналаар дамжуулан эцэг, эхчүүд хүүхдийнхээ сурлагын дүн болон ирцийн мэдээллийг хянах боломж бүрдсэн боловч журналын хөтлөлт болон мэдээллийн системийн хөгжүүлэлт нь хангалттай бус, суралцагч өөр сумын сургуульд шилжин суралцсан тохиолдолд программ дахь шилжилт хөдөлгөөний мэдээлэл нь заавал механик ажиллагааны тусламжтай бүртгэгдэхээр байна.

Ялангуяа бага ангийн үдийн цай хөтөлбөрт хамрагддаг сурагчид нь шилжиж байх хугацаандаа ирцийн мэдээнд илүү болон дутуу байдлаар 2 сургуульд бүртгэгдэх эрсдэлтэй байна. Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн “Хоолны зардлын норматив тогтоох тухай” 450 дугаар тогтоолоор үдийн цай, дотуур байрны хүүхдийн хоолны зардал нь 50 хувиар буюу үдийн цайны зардал 900 төгрөг, дотуур байрны хүүхдийн хоолны зардал 3475 төгрөг болж нэмэгдсэн байна.

Засгийн газраас боловсролын салбарт бодлогын тэргүүлэх ач холбогдол өгч, суралцагчдын суралцах эрхийн баталгааг хангах, сургалтын орчин нөхцөлийг сайжруулахад бүх талын дэмжлэг үзүүлж байгаагийн үр дүнд боловсролын хүртээмж, чанар жилээс жилд дээшилж байна.

#### ***А.1.2 Салбарын яамны бодлого хөтөлбөртэй орон нутгийн зарим дэд хөтөлбөрүүдийн агуулга давхардсан байна.***

- *ЕБС-ын бодлого, хөтөлбөрийг боловсруулахдаа хяналт шинжилгээ үнэлгээний тайлан, ерөнхий боловсролын чиглэлээр гадаадын төсөл хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн судалгаа, тайланд үндэслэн боловсруулаагүй байна.*

Аудитын хамрах хүрээний хугацаанд ерөнхий боловсролын чиглэлээр гадаадын төсөл хөтөлбөрийн хүрээнд нэг удаагийн хөндлөнгийн үнэлгээ хийсэн байна. Уг хөндлөнгийн үнэлгээг Швейцарын хөгжлийн агентлаг, Дэлхийн банкны хамтарсан санхүүжилттэй “Монгол улсад нийгмийн эгэх хариуцлагыг бэхжүүлэх” төслийг Монгол улсын Засгийн газартай хамтран 2015-2019 оныг хамруулж, сургуулийн орчны стандартын хэрэгжилтийн байдал, холбогдох стандартуудын бодит гүйцэтгэлтэй холбогдуулан хийжээ. Аливаа гадаадын хөрөнгө оруулалттай судалгаа, хяналт шинжилгээний төслүүд нь нийслэл хотод хэрэгжиж хөдөө орон нутгийн бодит байдал, анхны нэгжид хийгдэхгүй байгаа нь дутагдалтай байна.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн дээд хэмжээний 70 дугаар чуулган 2015 онд хуралдаж, “Эх дэлхийгээ өөрчлөх нь: Тогтвортой хөгжлийн хөтөлбөр 2030”-ийг баталжээ. Тогтвортой хөгжлийн 17 зорилгыг 2030 он гэхэд улс орон бүр хангах үүрэг

амлалтыг авч, Монгол Улс 2016 онд УИХ-ын 19 дүгээр тогтоолоор “Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030”-ыг баталсан байна. Тогтвортой хөгжлийн 17 зорилгын дөрөв дэх буюу боловсролын зорилго “Тэгш хамран сургах, тэгш боломжийг хангасан чанартай боловсрол, бүх нийтийн насан туршдаа суралцах боломжийг дэмжих” хэмээн тодорхойлжээ.

Үүний мөрөөр Монгол улсын боловсролын салбарын бодлогод тойм шинжилгээ хийлгэх нь зүйтэй хэмээн үзэж Монгол Улсын Засгийн газар, ЮНЕСКО-ийн хоорондын харилцаа, хамтын ажиллагааг уялдуулан зохицуулах үүргийг хүлээсэн ЮНЕСКО-ийн Монголын үндэсний комиссоос санаачлан Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны хүсэлтийг ЮНЕСКО-д тавьснаар Монгол Улсын боловсролын салбарын бодлогод тойм шинжилгээ хийхээр ЮНЕСКО-ийн мэргэжилтнүүд 2019 онд ажилласан байна.

Дээрх мэргэжилтнүүдийн гаргасан “Монгол улсын боловсролын суурь тайлан” хэмээх нэртэй судалгаа, шинжилгээний тайланг ашиглан шинээр боловсруулах эрх зүйн хэм хэмжээний актуудад ашиглах нь зүйтэй байна.

- *Ерөнхий боловсролын талаарх бодлого хөтөлбөр харилцан уялдаатай байгаа боловч орон нутгаас батлан гаргаж байгаа дэд хөтөлбөр нь давхардлыг бий болгож байна.*

Улсын хэмжээнд хэрэгжиж буй Боловсрол үндэсний хөтөлбөр нь 2010 оноос боловсролын бүхий л салбарт 2021 он хүртэл хэрэгжихээр байна. Уг хөтөлбөрийг Улсын Их Хурлын 2008 оны 12 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газраас батлан хэрэгжүүлж иржээ.

Засгийн газрын 2006 оны 194 дүгээр тогтоолоор батлагдсан Үдийн цай хөтөлбөр нь тасралтгүй хэрэгжиж ирсэн бөгөөд бодлогын түвшинд өнөөгийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн тодорхой үр дүнд хүрч байна. Засгийн газрын 2019 оны 450 дугаар тогтоолоор үдийн цайны тогтмол зардлыг нэмэгдүүлж, Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор 2020-2021 оны хичээлийн жилээс бага ангиудад, 2021-2022 онд дунд ангиудад, 2022-2023 онд ахлах ангиудад үдийн хоол хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр болжээ.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр нь 2018 оноос хэрэгжиж эхэлсэн бөгөөд БСШУС-ын сайдын А/292 дугаар тушаалаар Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ерөнхий боловсролын сургуульд тэгш хамран сургах журам нь шинээр батлагдан хэрэгжиж эхэлсэн нь хөтөлбөрийн хэрэгжих үр дүнг улам бататгаж байна.

Аудитын явцад: Засгийн газраас 2019 онд баталсан “Хүүхэд залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилттэй танилцахад хэрэгжилт, үр дүн сайтай байгаа бөгөөд сургуулийн сурагчдын идэвх санаачилгыг эцэг эхийн оролцоотойгоор нэмэгдүүлсэн сайн үзүүлэлттэй байна.

Аудитаар хамрагдсан ихэнх сургуулиуд хөтөлбөрийн 4.1.4 дэх хэсэгт заасны дагуу угийн бичиг хөтлөх арга хэмжээг эцэг эхийн оролцоотойгоор зохион байгуулж үр дүнд хүрсэн байна. Сургуулийн захиргаа, суралцагчид, эцэг эхийн хамтын ажиллагаа үр дүнтэй

байснаар эх оронч үзэл төлөвших, сургуулиудад сургалтын чанар сайжрах байдал ажиглагдаж байна.

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 55 дугаар тогтоолоор батлагдсан “Олон нийтийн оролцоот сургууль” дэд хөтөлбөр нь 2020 он хүртэл хэрэгжсэн байна. Дээрх онд батлагдсан “Шатар” аймгийн дэд хөтөлбөр нь хэрэгжилтийн хувьд үр дүнтэй байсан бөгөөд 2017-2020 онуудад хэрэгжихээр байна. Аймгийн ИТХТ-ийн 2017 оны 39 дүгээр тогтоолоор “Адил боломж” батлагдсан аймгийн дэд хөтөлбөр нь ЗГ-ын 321 дүгээр тогтоолоор “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих” үндэсний хөтөлбөрийн өмнө батлагдан хэрэгжиж эхэлжээ.

Ерөнхий боловсролын сургуулиудад хэрэгжиж буй үндэсний болон аймгийн дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх гол хөшүүрэг нь төсөв санхүүжилттэй шууд хамааралтай байна. Хөтөлбөрүүдийг батлан хэрэгжүүлэхдээ төсөв, санхүүжилтийн асуудлыг хэрэгжих хугацаанд нь тохируулан сайтар төлөвлөөгүйн улмаас хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнд нөлөөлж байгааг сургуулийн удирдлагууд тайлбарлаж байна.

Зарим тохиолдолд хөтөлбөрүүд агуулгын хувьд давхардаж байгаа нь хэрэгжүүлж буй ажилтнууд хэт их ажлын ачаалалтай байгааг онцолж байна. Тухайлбал:

- Хүүхдэд ээлтэй аймаг хөтөлбөр нь Хүүхдийн хөгжил хамгааллын үндэсний хөтөлбөртэй адил,
- Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр нь Адил боломж аймгийн дэд хөтөлбөртэй утга агуулга, хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь төстэй байна.

## ***A.2 Сургалтын хэрэгцээ шаардлага болон мэргэжлийн боловсон хүчин бүрэн хангагдсан, хүртээмжтэй материаллаг орчныг бүрдүүлсэн байна.***

### ***A.2.1 Хамран сургалтын тэгш, хүртээмжтэй орчныг бүрдүүлсэн байна.***

- *Аймгийн ИТХ-аас ерөнхий боловсролын байгууллагад хэрэгжүүлэх дэд хөтөлбөрүүдийг батлан, биелэлтийг тооцон ажиллаж байна.*

Боловсролын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2-т “орон нутгийн өмчийн боловсролын байгууллагыг хөгжүүлэх төлөвлөгөө батлах, биелэлтэд хяналт тавих” гэсэн заалтын дагуу аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс дэд хөтөлбөрүүдийг баталж, жил бүр биелэлтийг тооцон ажиллаж байна.


- *"Нэг ангид ногдох хүүхдийн тоо зохих түвшинд байна.*

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2007 оны 307/91/237 тушаалаар анги дүүргэлтийг бага ангид 30-35, дунд ахлах ангид 32-35, ахлах ангийн мэргэжлийн болон сонгон судлах хичээлийн бүлэг дүүргэлтийг 25-30, харах, сонсох эрхтний хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургуулийн бүлэгт 8-12, оюун ухааны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургуулийн бүлэгт 10-15 хүүхэдтэй байхаар зохион байгуулж ажиллахаар журамласан байна. 2019 оны сайжруулсан цөм хөтөлбөрөөр 10-12 дугаар ангиуд заавал судлах болон сонгон судлах хичээлийг холимог байдлаар хичээллэж болно гэжээ.

Аудитад хамрагдсан 17 сургуулийн дунджаар авч үзвэл аймгийн төвөөс алслагдсан сумдын сургуулийн анги дүүргэлт стандартын дагуу, харин аймгийн төвтэй ойр сумдын сурагчид нь сургалтын чанар, сургуулийн орчин нөхцөлөөс шалтгаалан аймгийн төвийн

сургуулиудад шилжин суралцах асуудал сүүлийн жилүүдэд нэмэгдэж байна. 2019-2020 оны хичээлийн жилийн аймгийн төвийн сургуулиудын бага ангийн дүүргэлтийг графикаар харуулбал:

Дүрслэл 1



#### **А.2.2 Ерөнхий боловсролыг олгоход шаардагдах хэвийн, аюулгүй материаллаг орчин, нөхцөл бүрдсэн байна.**

- "Сургалтын хэвийн үйл ажиллагаа явуулах шаардлага хангасан, зориулалтын барилга байгууламжтай байна.

Аудитад хамрагдсан 11 сумын ерөнхий боловсролын 17 сургуулийн үйл ажиллагаатай танилцахад сургалтын хэвийн тасралтгүй үйл ажиллагааг явуулах шаардлага хангасан, зориулалтын барилгатай байна. Зарим сумдын барилгын насжилт болон хүчин чадлаас давсан байдал нь сургалтын хэвийн үйл ажиллагааг явуулахад сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байна. Тухайлбал:

Бат-Өлзий сумын ЕБ-ын сургууль 1973 онд ашиглалтад орсон сургуулийн барилгыг Мэргэжлийн хяналтын газрын 2016 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн 15/07/025/175 тоот дүгнэлтээр 75.3%-ийн өндөр эрсдэлтэй хэмээн актлах шийдвэр гаргаж байсан байна. Гэтэл 2017 оноос хойш тус суманд шинээр сургуулийн барилга болон өргөтгөл баригдалгүй өнөөг хүргэсэн нь сургалтын үйл ажиллагааг тасралтгүй, хэвийн хэрэгжүүлэхийн тулд актлагдсан барилгад хичээллэх зайлшгүй шаардлага тулгарч байна.

Гучин-Ус сумын ЕБ-ын сургууль нь 1940 онд ашиглалтад орсон бөгөөд барилгын элэгдлийн хугацаа 2000 онд дууссан, 2016 онд 240 хүүхдийн хүчин чадал бүхий сургуулийн өргөтгөлийн барилгыг барьж ашиглалтад оруулсан байна.

- Сургуулийн барилга, номын сан, спорт заал, дотуур байрны барилгад жил бүр урсгал завсар хийгдээгүй, сургуулийн эзэмшил газарт зориулалтын бус барилга байгууламж баригдаж сургалтын орчинд сөргөөр нөлөөлөөгүй байна.

Арвайхээр, Хужирт, Богд, Бат-Өлзий, Гучин-Ус, Төгрөг, Тарагт зэрэг сумдын ЕБ-ын сургууль болон дотуур байруудад урсгал засвар хийгдсэн байна. 2016 онд 82.7 сая төгрөг, 2017 онд 137.9 сая төгрөг, 2018 онд 216.4 сая төгрөгийн урсгал болон их засваруудыг хийж гүйцэтгэсэн байна. Сүүлийн жилүүдэд боловсролын салбарт тэр дундаа сургуулиудад ихээхэн хэмжээний хөрөнгө оруулалтын ажлууд хийгдсэн боловч сургуулиудын барилгын ашиглалтын хугацааг нэмэгдүүлэхээр их засварын ажлыг цогц байдлаар авч хэрэгжүүлээгүй, хэрэгцээ шаардлагыг сайтар судлаагүй, хэсэгчилсэн байдлаар хийгддэг зэрэг нь барилгын ашиглалтыг сайжруулах тал дээр үр дүнтэй ажил болж чадахгүй байна.

Сургуулийн эзэмшил газарт өөр зориулалтын барилга байгууламж баригдаж, ашиглалтад орсон асуудал аудитын явцад илрээгүй болно.

- *Сургуулийн анги танхимыг зориулалтын дагуу ашиглаж байна*

Цөм хөтөлбөр хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор хичээлийн агуулга стандарт шинэчлэгдэн хими, физик, эрэгтэй, эмэгтэй технологи зэрэг хичээлийг заавал кабинетын системээр хичээллүүлж сурагчдад онолын мэдлэгийг дадлага ажил, туршилттай хослуулан олгох нь үр дүнтэй байна. Аудитад хамрагдсан 17 сургуулиас 4 сургууль /Мэргэд, Арвайхээр сумын ЕБ-ын 2 дугаар сургууль, Бат-Өлзий сумын ЕБС, Хархорин сумын ЕБ-ын 1 дүгээр сургууль/ химийн хичээлийн танхимдаа холбогдох тусгай зөвшөөрлийг авсан бөгөөд бодис, урвалжийг сургалтад ашиглах зөвшөөрөлтэй байна.

6 настны анги танхимын хувьд ангийн үндсэн талбайгаас гадна тоглох нэмэлт /өрөө/ орон зай, номын сангийн булан, үзүүлэх болон сургалтын хэрэглэгдэхүүн байрлуулах талбай, хувцасны өлгүүрийн талбайтай байх шаардлагыг тавьдаг байна. Хархорин сумын ГСЕБС, Уянга сумын ЕБ-ын 2 дугаар сургуулиудын 6 настны анги танхим нь зориулалтын ариун цэврийн өрөө, тоглох нэмэлт өрөөтэй бөгөөд зохих сургалтын хэрэглэгдэхүүнтэй байна.

- *"ЕБС-ийн дотоод орчны аюулгүй байдал бүрэн хангагдсан боловч гадаад орчны хүүхдийн аюулгүй байдал бүрэн хангагдаагүй байна.*

Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн 3<sup>1</sup> дугаар зүйлд заасны дагуу сургуулийн орчин гэдэг нь сургуульд эзэмшүүлсэн газар, түүнээс эргэн тойронд 150 метр хүртэлх газрыг ойлгохоор хуульчилсан байна. Аудитад хамрагдсан сургуулиудын хувьд Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2019 оны С/40 дүгээр тушаал "MNS 6782:2019"-аар батлагдсан стандартын гадаад орчинд тавигдах аюулгүй байдлын шаардлага бүрэн хангагдаагүй байна.

Мөн Богд, Бат-Өлзий, Баруунбаян-Улаан, Хужирт, Гучин-Ус, Хайрхандулаан, Арвайхээр сумын 1 дүгээр сургууль, 2 дугаар сургуулиудын орчинд зарах хориотой хүнсний бүтээгдэхүүнийг худалдан борлуулж байна. Тамхи татдаг байж болзошгүй, татдаг сурагчдын судалгааг сургуулийн нийгмийн ажилтнууд гаргасан байгаа боловч дээрх сургуулиудын орчинд тамхи худалдан борлуулж байна.

Архи, согтууруулах ундаа, тамхи худалдан борлуулдаг, түүгээр үйлчилдэг газруудын тусгай зөвшөөрлийг олгохдоо хуульд заасан стандартыг баримтлан ажиллах шаардлагатай байна.

---

<sup>1</sup> "3.1.4. "сургуулийн орчин" гэж сургуулийн байр, дотуур байр болон Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.1 дэх заалтад заасны дагуу сургуульд эзэмшүүлсэн газар, түүнээс эргэн тойронд 150 метр хүртэлх газрыг "



- *Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдсэн тавилга, эд хогшил хүрэлцээтэй зохих шаардлагыг хангасан, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн ашиглалт хангалттай байна.*

Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын орчныг шинэчлэн тохижуулах, сургалтын хэрэглэгдэхүүн тоног төхөөрөмжөөр хангах бодлогын хүрээнд улс болон орон нутгийн хөрөнгө оруулалт, ОУ-ын төсөл хөтөлбөрийн байгууллагуудтай хамтран ажилласан байна.

БСШУС-ын яамны хөрөнгө оруулалтаар 2016 онд 10 сургуульд багш, сурагчдын ширээ, сандал, номын шүүгээ, гал тогооны иж бүрдэл тоног төхөөрөмж, 10 сургуульд физикийн лабораторийн ширээ багаж хэрэгсэл, 2 сургуульд роботын кабинет, ширээний компьютер зэрэг 41 нэр төрлийн 378.2 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг нийлүүлэгдэж бүрэн ашиглаж байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2018 онд 94.0 сая төгрөгийг Тарагт сумын ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмж, Арвайхээр сумын 5 дугаар сургуульд 200 ширхэг ширээ сандал, ЕБ-ын 18 сургуульд эмчийн ажлын байранд шаардлагатай байгаа 6 нэр төрлийн багаж зэргийг мөн 50.0 сая төгрөгөөр ЕБ-ын сургуулийн 29 дотуур байрны хатуу, зөөлөн эдлэлийг хөрөнгө оруулалтаар шийдвэрлэж хэрэгцээ шаардлагыг хангасан байна.

БСШУС-ын яамны хөрөнгө оруулалтаар 2019 онд 9 сургуульд 17 нэр төрлийн 110.4 сая төгрөгийн тавилга, эд хогшил, тоног төхөөрөмж нийлүүлсэн байна. Улс болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдсэн тавилга, эд хогшил, тоног төхөөрөмжийн ашиглалт хангалттай бүрэн ашиглаж байна. Аймгийн хэмжээнд сурагчдын тээврийн хэрэгсэлтэй сургууль байхгүй. Харин 2020 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар ЕБ-ын 11 сургуульд уралдаан тэмцээнд явах сурагчдын тээврийн хэрэгсэлтэй болгох ажил хийгдэж эхэлсэн байна.

### ***А.2.3 Зарим мэргэжлийн багшийн эрэлт хэрэгцээ их байна.***

- *Мэргэжлийн боловсон хүчний хүрэлцээ хангалттай, зарим мэргэжлийн багшийн эрэлт хэрэгцээ гарсан байна.*

Ерөнхий боловсролын сургуульд багшилж буй багш нарын хүрэлцээ нь хангалттай байгаа бөгөөд зарим мэргэжлийн багш нарын шилжилт хөдөлгөөн их байдгаас шалтгаалан эрэлт үүсэж байна. Тухайлбал хими, математик, эрэгтэй технологи, дуу хөгжмийн багш нар юм.

Аудитын явцад элсэлтийн ерөнхий шалгалтад бэлтгэдэг мэргэжлийн багш нарын хүрэлцээг тодруулахад зохих хэмжээгээр мэргэжлийн боловсон хүчнийг жил бүр шинээр авч ажиллуулж байгаа тул дутагдалтай багш байхгүй байна. Аудитад хамрагдсан сургуулиудын хувьд нийгмийн ажилтны хүрэлцээ хангалттай байгаа бөгөөд Уянга сумын ЕБ-ын 1 дүгээр сургууль, Хайрхандулаан сумын ЕБС мэргэжлийн номын санчгүй байна.

- *Багшийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааг үр дүнтэйгээр зохион байгуулж байна.*

Багшийн хөгжлийг дэмжих тухай хууль батлагдахаас өмнө багшийг мэргэжлийн ур чадвар, мэдлэг, сургалтын арга зүйг сайжруулах чиглэлээр Боловсролын<sup>1</sup> тухай хуульд заагдсаны дагуу онолын мэдлэг, заах арга, ур чадвараа дээшлүүлэхийг багш нарт үүрэг болгон зохицуулж байжээ.

Багшийн хөгжлийг дэмжих талаарх тогтолцоонд орон нутгийн хувьд Засаг дарга, Боловсрол соёл урлагийн газар, сургуулийн захирал, сургалтын менежер голлох үүргийг хэрэгжүүлэх бөгөөд хамгийн гол хэрэгжүүлэгч нь багш өөрөө юм.

Аудитын явцад Суурь боловсрол, бүрэн дунд боловсролын хүрээнд Арвайхээр, Хархорин сумдын сургуулиудын багш нар нь өөрийн заах арга зүйгээ сайжруулах, туршлага судлах, онолын мэдлэгийг дээшлүүлэх, хичээл сургалтдаа шинэлэг санаа дэвшүүлэн нэмэлтээр зарим программ ашиглаж байгаа сайн туршлагууд байна.

Бусад сумдын сургуулийн багш нарын хувьд төдийлөн үр дүнтэйгээр бодит ажил болгон өөрийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлсэн сайн туршлага байсангүй. Багшийн мэргэжил дээшлүүлэх институтээс жил болгон зохион байгуулдаг мэргэжил, ур чадварыг дээшлүүлэх зорилготой Үндсэн сургалт нь богино хугацаанд хичээллэж багшийг байнга ажлын байран дээрээ хөгжих нөхцөл бололцоогоор хангах ажил дутагдалтай байна.

Мөн бусад мэргэжлийн байгууллагууд болон хөндлөнгийн байгууллагуудаас хийгддэг сургалт нь төдийлөн үр нөлөөтэй бус байна. Багш нь мэргэжлийн мэдлэгээ дээшлүүлсэн, заах арга зүйн ур чадвараа ахиулсан, бүтээлчээр хандсан сайн багшаас сайн шавь бэлтгэгдэн гарснаар улс орны хөгжил, дэвшилд эерэг нөлөө үзүүлэх учиртай.

Аймгийн Боловсрол, соёл урлагийн газар нь 2018-2019 оны хичээлийн жилээс эхлэн MOODLE нэртэй цахим кампусыг ашиглаж байгаа нь багшийг ажлын байран дээр нь тасралтгүй хөгжүүлэх, мэргэжлийг дээшлүүлэх, чадавхжуулах сургалтыг онлайнаар зохион байгуулах, сурагчдаас авах шалгалтын нэгдсэн сантай болох, сумдын багш, удирдлагуудтай байнгын тасралтгүй холбоотой байх зэрэг олон давуу талтай үйл ажиллагаа болсон байна.

Иймд цахим кампус нь бусад орон нутагт хэрэгжээгүй бөгөөд манай аймгийн хувьд орон нутгуудаас анхдагч байж нутагшуулан ажиллаж байгааг онцлох нь зүйтэй.

Гэсэн хэдий ч энэхүү цахим кампусын гол хэрэглэгч болсон багш нар нь мэргэжлийн арга зүйчдийн бэлтгэсэн сургалтын арга зүй, сайн туршлага, шинэ санаа, бусад сумдын сайн, туршлагатай багш нарын арга зүйг өөрсдийн сургалтын үйл ажиллагаанд нэвтрүүлэх тал дээр хангалтгүй байна. Цаашид цахим кампусаар дамжуулан багш нарын хөгжилд тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

Багшийн хөгжлийг дэмжих хүрээнд МУ-ын зөвлөх, тэргүүлэх зэрэгтэй бага ангийн багш нарын туршлагыг түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааг сургууль бүр дээр уламжлал болгон зохион байгуулсан байна. Аймгийн хэмжээнд МУ-ын зөвлөх зэрэгтэй бага ангийн сургалтын менежер 1, бага ангийн багш 4, тэргүүлэх зэрэгтэй бага ангийн багш 124 байна.

Сургууль бүрийн зөвлөх, тэргүүлэх зэрэгтэй багш нар сургалт зохион байгуулах, хэлэлцүүлэгт хичээл заах, арга зүйн зөвлөгөө өгөх, гарын авлага зөвлөмж бэлтгэх, нэрэмжит ажлууд зохион байгуулах, үр дүнг тооцох, зэргээр багш бүр оролцсон үйл ажиллагааг зохион байгуулж хэвшжээ.

---

<sup>1</sup> “44.2.3.онолын мэдлэг, заах арга, ур чадвараа дээшлүүлэх”

Үүний үр дүнд залуу багш нарыг дагуулан сургах, хамтран ажиллах үйл ажиллагаа сайжирсан байна. Энэ үйл ажиллагааг улсын хэмжээнд түгээн дэлгэрүүлж Арвайхээр сумын 1 дүгээр сургуулийн багш Д.Цэцэгмаа 2019 онд МУ-ын зөвлөх багш зэрэг авсан байна.

Мөн бага ангийн багш нарын заах арга зүй ур чадварыг дэмжих чиглэлээр:

- 2017-2018 оны хичээлийн жилд Зөвлөх, тэргүүлэх зэрэгтэй багш нарын нэрэмжит аян зохион байгуулж сайн хичээл, сайн технологийн уралдаанд 6 судлагдахуун тус бүрээр бүс бүсээс шалгарсан 39 хичээлийн 6 хичээлийг улсын технологийн санд, 8 багшийн хичээлийг аймгийн технологийн санд бүртгэсэн байна.
- Сургууль бүр дээр зохион байгуулагдаж байгаа багш нарын ур чадвар, заах арга зүйг сайжруулах үйл ажиллагааны үр дүнд 2019 онд БСУГ-аас зохион байгуулсан аймгийн залуу багш нарын ур чадварын уралдаанд ЕБ-ын 30 сургуулиас шалгарсан 1-15 жил ажиллаж байгаа 29 багшийн 14 нь буюу 50% нь бага ангийн багш нар оролцсон байна.
- Арвайхээр сумын 1 дүгээр сургуулийн багш нарын 5-р ангийн байгалийн ухаан хичээлээр боловсруулсан тэмдэглэлд суурилсан хичээлийн хэлэлцүүлэг аймгийн хэмжээнд түгээн дэлгэрч БНХАУ-д туршлага судлах уулзалт, илтгэлд оролцсон байна.

Аймгийн сургуулиудын бага ангийн багшийн хөгжлийг БСУГ-аас ажлын байран дээрээ тасралтгүй хөгжих, онол мэргэжлийн арга зүйг нэмэгдүүлэх чиглэлээр олон төрлийн ажлыг үр дүнтэйгээр зохион байгуулсан байна.

- *"Сургуулийн захирал, сургалтын менежер, багш нь холбогдох шалгуурт нийцэж байгаа боловч зарим багш багшлах эрхгүй байна.*

Сургуулийн захирал, сургалтын менежерүүдийн ажилд тэнцэх шалгуурыг ажлын байрны тодорхойлолтын дагуу зохих шаардлагыг хангасан, мэргэжлийн болоод ажлын туршлагатай, удирдан чиглүүлэх чадвартай, ахисан түвшний боловсролын зэрэгтэй байгаа нь холбогдох шалгуурт нийцэж байна.

Уянга сумын ЕБ-ын 2 дугаар сургууль, Хайрхандулаан сумын ЕБ-ын сургууль, Хархорин сумын ЕБ-ын 1 дүгээр сургуулиудын хувьд бага ангийн сургалтын менежер нь Монгол хэл, Англи хэл, Газарзүйн багш нар байна.

Бага ангийн багшийг шатлан дэвшүүлэхгүй байгаа нь багшид өгөх арга зүйн зөвлөгөө оновчгүй, мэргэжлийн онолын мэдлэг дутмаг, математик сэтгэлгээг хөгжүүлэх, бодлого бодох, математик заах арга зүйг өгч чадахгүй байгаа нь сургалтын чанарт сөргөөр нөлөөлөхөөр байна. Бага ангийн сургалтын менежерийн ажлын байрны тодорхойлолтын тусгай шалгуурыг заавал бага ангийн багш байхаар тогтоож байх нь зүйтэй байна.

Бусад багш нар мэргэжлийн дагуу ажлын байрны тодорхойлолтод заагдсан шаардлагыг бүрэн хангасан байна. Харин үндсэн орон тоонд ажиллаж байгаа багш нь багшлах эрхгүй байгаа тохиолдол аудитын явцад илэрч байна.

Үүнд: Багшлах эрхгүй багш нарын жагсаалт

Хүснэгт 1

№	Сум, сургуулийн нэр	Багшийн овог нэр	Ямар хичээл заадаг талаар	Илэрсэн зөрчил
1		Д.Биндэръяа	Биеийн тамир, эрүүл мэндийн багш	Төрийн сангийн зээлээр сурсан. Төлбөрийг төлөөгүй учраас диплом эх хувиараа байхгүй.

2	Уянга сумын ЕБ-ын 2 дугаар сургууль	Б.Батжаргал	Биеийн тамир, эрүүл мэндийн багш	Төрийн сангийн зээлээр сурсан. Төлбөрийг төлөөгүй учраас диплом эх хувиараа байхгүй.
3		Э.Энхжаргал	Дизайн технологийн багш	Төрийн сангийн зээлээр сурсан. Төлбөрийг төлөөгүй учраас диплом эх хувиараа байхгүй.
4		Ч.Батхуяг	Дизайн технологийн багш	Багшлах эрхгүй
5	Хужирт сумын ЕБСургууль	Э.Батзаяа	Биеийн тамирын багш	Багшлах эрхгүй
		Ц.Цэрэнханд	Бага ангийн багш	Төрийн сангийн зээлээр сурсан. Төлбөрийг төлөөгүй учраас диплом эх хувиараа байхгүй.
6	Хархорин сумын ЕБ-ын 1 дүгээр сургууль	Х.Сүхбат	Нийгмийн ажилтан	Мэргэжлийн бус
7	Арвайхээр сумын ЕБ-ын 1 дүгээр сургууль	Б.Адъяадолжин	Биеийн тамирын багш	Багшлах эрхгүй
8		С.Алтангэрэл	Биеийн тамирын багш	Багшлах эрхгүй


- *ЕБС-ийн хүний нөөцийн бодлого оновчтой, бодлогын хэрэгжилт үр дүнтэй байна*

Багшийн мэргэжлээр их дээд сургууль төгсөгчдийн хувьд сумдад очиж ажиллах сонирхол бага байдаг нь амьдрах орчин нөхцөл, нийгмийн баталгаанаас шалтгаалж байна. Үүнээс гадна аймгийн төвд 2019 онд шинэ сургууль ашиглалтад орсонтой холбоотойгоор сумдаас мэргэжлийн багш нарыг татан ажиллуулах асуудал гарч, сумдын сургуулиудад багшийн эрэлт хэрэгцээ ихээр нэмэгдсэн хэдий ч сургуулиудын тэгш хүрэлцээ алдагдаагүй байна.

- *Боловсрол, соёл, урлагийн газрын зүгээс багшийн эрэлт, хэрэгцээний талаар судалгааг гаргаж сул орон тоог нөхөж ажилласан байна.*

БСУГ-ын зүгээс 2016-2019 онуудад аймгийн нийт сургуулиудаас багш нарын эрэлт хэрэгцээний судалгааг авч түүний мөрөөр багшийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулж ажилласан байна. Судалгааны үр дүнд шаардлагатай байгаа багшийг сумдын саналын дагуу хуваарилан ажиллуулж байна. Аймгийн БСУГ-аас багшийн эрэлт хэрэгцээний судалгааг нэгтгэн гаргасныг харуулбал:

Дүрслэл 2



Дээрх харьцуулалтаас харвал багшийн байнгын орон тоо нь жил бүр тасралтгүй нэмэгдэж байгаа бөгөөд нийт багшийн эрэлт хэрэгцээ аймгийн хэмжээнд их байгааг харж болно. Жил бүрийн судалгааны дүнгээс авч үзвэл математик, эрэгтэй технологи, дуу хөгжим, хими зэрэг хичээлийн мэргэжлийн багш нарын хомсдол аймгийн хэмжээнд бий болсон байна.

### **А.3 Ерөнхий боловсролын үйл ажиллагааны санхүүжилт бодитой төлөвлөгдөн ихэнх зардлыг зориулалтын дагуу зарцуулж байна.**

#### **А.3.1 Төсвийг бодитой төлөвлөж, хүүхдийн тоотой уялдуулан хуваарилсан байна.**

- Төрөөс сургуулиудад олгож буй хувьсах зардлыг онцлог, хэв шинжтэй уялдуулан бодитой төлөвлөж байна.

Аймгийн хэмжээнд 2017-2019 оны төсвийн төслийг дараах байдлаар төлөвлөж, төсөв батлагдсан байна. Үүнд:

Хүснэгт 2 /сая.төг/

д/д	Төсөв төлөвлөлт	2017	2018	2019
1	БСУГазраас БСШУС-н яаманд явуулсан төсөв	26776.6	26223.9	30478.3
2	БСШУС-ын яамнаас УИХ өргөн барьсан төсөв	26475.9	26689.8	27649.3
3	БСШУС-ын яамнаас БСУГазарт батлагдсан төсөв	27032.9	26689.8	27649.3

БСУГ-т батлагдсан төсвөөс нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал зардалд 2017 онд 557.1 сая төгрөг, 2018 онд 465,9 сая төгрөгийг тус тус нэмж олгосон, 2019 онд нийт зардлаас 2829.1 сая төгрөгийг хасаж баталсан нь тогтмол зардлыг орон нутгаас санхүүжүүлэхээр өөрчлөлт орсонтой холбоотой байна. Энэ нь орон нутгийн харьяа

байгууллагуудыг өмчийн хэлбэрээр нь бүрэн шилжүүлэн ашиглалтын зардал болох тогтмол болон урсгал засварын зардлыг орон нутгийн мэдэлд шилжүүлж санхүүгийн дэмжлэгээр дамжуулан хуваарилж эхэлсэн байна.

Төсвийн хуваарилалтыг суралцагчдын тоотой уялдуулан тооцож хуваарилсан байна.

- *Дотуур байрны хүүхдийн хоолны зардлын төсвийг үндэслэлтэй төлөвлөсөн байна.*

Аймгийн хэмжээнд 21 сумын 30 дотуур байртай, дунджаар 2444 хүүхэд суух хүчин чадалтай байна. 2016-2019 оны хичээлийн жилд дунджаар 2331 хүүхэд байранд суулгахаар төлөвлөж төсвийн төсөлд тусгажээ. Дотуур байрны хүүхдийн хоолны зардлыг төсвийн төсөлд өгсөн саналаас 2017 онд 13.1 сая төгрөг, 2018 онд 16.4 сая төгрөгийг хасаж баталсан байна.

Дотуур байрны хувьсах зардлын төсвийн төсөлд цалингийн норматив зардлыг дараах байдлаар тооцсон байна.

Хүснэгт 3 /мян.төг/

Он	Хүүхдийн тоо			Цалингийн норматив		Цалингийн зардал		
	6 настай	7-18 настай	Нийт	6 настай	7-18 настай	6 настай	7-18 настай	Нийт
2016	150	2249	2399	299.4	199.3	44910.0	448225.7	493135.7
2017	157	2259	2416	402.8	268.2	63239.6	605863.8	669103.4
2018	157	2241	2398	402.8	268.2	63239.6	601036.2	664275.8
2019	245	2098	2343	402.8	268.2	98686.0	562683.6	661369.6

Дээрх хүснэгтээс харахад: Дотуур байрны хувьсах зардлын төсвийн төслийг тогтоосон норматив зардлаар нь тооцож төсөвлөсөн байна.

- *Ном, сурах бичигт шаардлагатай хөрөнгийг бодитой тооцож төлөвлөж байна.*

БСУГазар ном, хэвлэлийн зардлын бодит, хэрэгцээ шаардлагад нийцүүлэн, сургуулиудын номын санд шаардлагатай номыг авахаар үндэслэлтэй төлөвлөж төсвийн төсөлд тусгаж байгаа боловч 2017 онд 5.8 сая төгрөг, 2018 онд 7.7 сая төгрөг, 2019 онд 15.3 сая төгрөгийг тус тус хасаж төсвийг баталж өгсөн байна.

- *Шаардлагатай гарын авлага, сургалтын үзүүлэн болон бусад хэрэглэгдэхүүний төсвийг төлөвлөөгүй байна.*

Шаардлагатай гарын авлага, сургалтын үзүүлэн болон бусад хэрэглэгдэхүүнийг төсөвт төлөвлөж тусгаагүй байна.

### **А.3.2 Санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулж байгаа боловч үдийн цай хөтөлбөрийн зарцуулалт хангалтгүй байна.**

- *Санхүүжүүлэх зардлын гүйцэтгэлийг хүүхэд өдрөөр хянаж, цаг тухайд нь бүрэн олгосон боловч дотуур байрны хүүхдийн хоолны зардлын хяналт хангалтгүй байна.*

БСУГазрын төсвийн мэргэжилтэн нь санхүүжүүлэх зардлын гүйцэтгэлийг хүүхэд өдрөөр хянаж олгодоггүй, хэмнэгдсэн зардлыг жилийн эцэст тодотголоор бүлэг хооронд гүйлгэн зарцуулж иржээ.

Дотуур байрны хүүхдийн хоолны зардал нь дунджаар нийт төсвийн 3.8 хувийг эзэлж байна.

Дотуур байрны хүүхдийн хоолны зардлын 2016-2019 оны санхүүжилт:

Хүснэгт 4 /сая.төг/

д/д	Он	Төлөвлөлт	Гүйцэтгэл	Хэмнэлт/+/ Хэтрэлт/-/
1	2016	1137.2	1131.8	5.4
2	2017	1093.8	1062.1	31.7
3	2018	973.8	965.3	8.5
4	2019	965.6	964.0	1.6
	Нийт дүн	4170.4	4123.2	47.2

Аудитад хамрагдсан 17 ЕБС-ийн 11 дотуур байрны хоолны зардлын гүйцэтгэлийг 3 хичээлийн жилээр, санхүүгийн тайлангийн 4 жилээр тооцож, нярвын хүнсний тайлан дахь хүүхэд өдөр тогоочийн бичсэн шаардах хуудасны хүүхэд өдөртэй таарч байгаа боловч дотуур байрны ирцийн журнал, нярвын тайлангийн хүүхэд өдөртэй тулгалт хийхэд таарахгүй маш их зөрүүтэй байна. Сургуулийн захирал, байрын багш, нягтлан бодогч, нярав нар дотуур байрны ирцийн журнал бүртгэл нь санхүүгийн үндсэн баримт бичиг гэдгийг бүрэн ойлгоогүй байна. Тухайлбал:

- Бат-өлзий сумын ЕБС-ийн дотуур байрны хүүхдийн ирцийн журнал нь 2016-2018 онуудад нярвын тайлангаас 1344 хүүхэд өдрөөр дутуу, 2019 онд 193 хүүхэд өдрөөр илүү байна. “Засгийн газрын 2012 оны 106 дугаар тогтоолоор Нэг хүүхдэд ноогдох норматив зардал 2315 төгрөг байхаар тогтоосон” байхад тус сургуулийн дотуур байрны хүүхдийн хоолны норматив зардал дунджаар 2268 төгрөгөөр олгосон байна.
- Уянга сумын 1 дүгээр сургуулийн дотуур байрны хүүхдийн хоолны зардлыг 2016 онд 15.6 сая төгрөг, 2017 онд 0,5 сая төгрөг, нийт 16.1 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.
- Хархорин, Хужирт, Төгрөг, Богд, Баруунбаян-Улаан, Нарийнтээл, Хайрхандулаан сумдын ЕБС-ийн дотуур байрны ирцийн журналын хүүхэд өдрийг нярвын тайлангийн хүүхэд өдөртэй тулгалт хийх гэсэн боловч ирцийн журнал дутуу, байхгүй, олдохгүй, байрны жижүүрийн ирцийн тэмдэглэл хангалтгүй байна.

Хүнсний тайлангаар материалын үлдэгдэл дараах байдалтай байна:

Хүснэгт 5 /сая.төг/

д/д	Сумдын нэр	2016	2017	2018	2019
1	Арвайхээр 1-р сургууль	4.6	2.0	2.0	0.3
2	Бат-өлзий	5.2	7.5	8.5	5.0
3	Богд	5.0	3.5	4.8	8.3
4	Баруунбаян-Улаан	12.6	10.3	22.1	11.5
5	Гучин-ус	6.9	3.3	5.0	1.6
6	Төгрөг	14.8	13.2	20.1	18.1
7	Нарийнтээл	8.4	8.7	11.3	4.3
8	Уянга 1-р сургууль	0.0	10.8	7.8	0.0
9	Хархорин 1-р сургууль	0.5	0.4	0.8	0.7
10	Хайрхандулаан	3.9	12.3	10.6	6.8
11	Хужирт	4.1	10.2	3.4	3.6
	Нийт дүн	66.0	82.2	96.3	60.2

Хүнсний тайлангаар материалын үлдэгдэл ихтэй байгаа Бат-өлзий, Богд, Баруунбаян-Улаан, Нарийнтээл, Хайрхандулаан, Хужирт зэрэг сумдын ЕБС-ийн нярвын хүнсний үлдэгдлийг тулган баталгаажуулан хяналтын тооллого хийхэд Нарийнтээл сумын ЕБС-ийн хүнснээс 3697.6 мянган төгрөгийн мах дутагдсан зөрчил илэрлээ. Аудитын явцад Төгрөг сумын ЕБС дээр аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албанаас шалгалт хийж байсан тул хяналтын тооллого хийгээгүй болно.

- *Ном, сурах бичгийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан байна.*

Ном, хэвлэлийн зардал нь дунджаар нийт төсвийн 0.05 хувийг эзэлж байна.

ЕБС-ийн 2016-2019 онуудад батлагдсан төсвийг жилийн эцсийн санхүүгийн тайлангийн гүйцэтгэлтэй тулгахад дараах байдалтай байна.

2016-2019 оны санхүүжилт

д/д	Он	Төлөвлөлт	Гүйцэтгэл	Хүснэгт 6 /мян.төг/
				Хэмнэлт/+/ Хэтрэлт/-/
1	2016	24.1	16.2	7.9
2	2017	12.3	9.8	2.5
3	2018	15.0	11.9	3.1
4	2019	12.4	11.3	1.1
	Нийт дүн	63.8	49.2	14.6

Ном, хэвлэлийн зардалд 2016-2019 онуудад нийт 49.2 сая төгрөгийг зарцуулжээ. Үүнээс: номын зардалд 22.7 сая төгрөг, хэвлэлийн захиалгат 20.2 сая төгрөгийг зориулалтын дагуу зарцуулсан боловч бичиг хэрэг болон бусад зардалд 6.3 сая төгрөгийг Сангийн сайдын 2013 оны 73<sup>1</sup> дугаар тушаалаар батлагдсан журмын дагуу гүйлгэн зарцуулсан байна.

- *"Багшийн хөгжлийг дэмжих үйл ажиллагаанд төсвөөс хөрөнгө батлаагүй байна.*

Багшийн хөгжлийг дэмжих үйл ажиллагаанд зарцуулах зардлын төсвөөс хөрөнгө батлуулаагүй байна. Харин багш хөгжлийн төвийг сум орон нутгийн зүгээс орон нутгийн хөгжлийн сан, төгсөгчдийн хандиваар тохижуулсан байна.

- *Төрийн сан нь ерөнхий боловсролын сургуулийн хувьсах зардлын олголтод хяналт тавьж санхүүжүүлж байна.*

Төсвийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.7<sup>2</sup> дах хэсэгт заасны дагуу аймгийн Засаг даргын захирамжаар төсвийн сар, улирлын хуваарийг баталж санхүүжилтийг төрийн сангийн хэлтсээс хяналт тавин олгож байна.

<sup>1</sup> Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт "Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам"-ын 5.5 "Зардлын бүлэг хооронд зохицуулалт хийх"

<sup>2</sup> Төсвийн тухай хуулийн 65.1.7 "аймаг, нийслэлийн жилийн төсвийн сар, улирлын хуваарийг баталж, мөрдүүлэх"



- Үдийн цай хөтөлбөр хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг хүүхэд өдрөөр тооцож олгож байгаа хэдий ч гүйцэтгэлээр хүүхэд өдрийн хяналт хангалтгүй байна.

Аудитад хамрагдсан ерөнхий боловсролын 17 сургуулийн үдийн цай хөтөлбөрийн хэрэгжилтийг үзэхэд 2016, 2018, 2019 онуудад 3093.0 сая төгрөгийн төсөв батлагдсанаас, 3076.2 сая төгрөгийн гүйцэтгэл гарч, оны эцэст төсөвт нийт 16.8 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

#### Үдийн цайны санхүүжилт

Хүснэгт 7 /сая.төг/

д/д	Он	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэмнэлт/+/ Хэтрэлт/-/
1	2016	1028.8	1028.3	0.5
2	2018	1050.3	1041.1	9.2
3	2019	1013.9	1006.8	7.1
	Нийт дүн	3093.0	3076.2	16.8

Засгийн газрын 2012 оны 106<sup>1</sup> дугаар тогтоолоор нэг хүүхдийн үдийн цайны өдрийн зардлыг 600 төгрөгөөр тогтоосны дагуу аудитад хамрагдсан сургуулиуд 2016, 2018, 2019 онд дундаж гүйцэтгэлээр 17569 хүүхдэд 808.1 сая төгрөгийг зарцуулжээ./Хавсралт 1/

Аудитад хамрагдсан сургуулиудаас дотроо гал тогоотой 10 сургууль, ААН-тэй гэрээ байгуулан нийлүүлсэн 7 сургууль байна.

Сургуулиудын ангийн багшийн журнал, сурагчдын өдөр бүрийн ирцийн бүртгэл, жижүүрийн дэвтэрт бүртгэсэн ирц, бэлтэн нийлүүлэгч байгууллагын нэхэмжлэлд бичсэн сурагчдын тоог тулган шалгахад багш нар ирцийг үнэн зөв бүртгээгүй, засварласан зэрэг дутагдал 2016-2019 оны хичээлийн жилд нийтлэг байна.

Бат-өлзий, Хужирт, Хархорин сумын 2 дугаар сургууль, Төгрөг, Богд, Арвайхээр сумын 1 дүгээр сургууль, 2 дугаар сургуулиудын ирц хөтлөлт хангалтгүй, бүртгэсэн эсэх нь тодорхойгүй, Хайрхандулаан сумын 2017-2018 оны хичээлийн жилийн 2<sup>б</sup> анги, 2018-2019 оны хичээлийн жилийн 4<sup>б</sup> ангийн журнал огт байхгүй зөрчил илэрсэн.

Харин Арвайхээр сумын 4 дүгээр сургууль, Мэргэд лаборатори сургууль, Гучин-ус сумын сургуулиудын бага ангийн сургалтын менежер сурагчдын ирцийн мэдээлэлд өдөр тутам хяналт тавьж ажилласан байна.

Үдийн цайны санхүүжилтийн хэмнэлтийг төсөвт буцаан төвлөрүүлэхгүйгээр материалын үлдэгдлээр тайлагнасан зөрчил илэрч байна.

Хүснэгт 8 /сая.төг/

	Сумдын нэр	2016 он	2018 он	2019 он
1	Богд ЕБС	0.3	1.0	1.4
2	Төгрөг ЕБС		6.6	7.8
3	Нарийнтээл ЕБС	1.3	4.2	4.9
4	Уянга сумын ЕБ 2-р сургууль			0.3
5	Хархорин сумын ЕБ 2-р сургууль			0.5
6	Хайрхандулаан ЕБС	4.2	7.4	5.1
7	Хужирт ЕБС		3.0	3.1
	Нийт дүн	5.8	22.2	23.1

<sup>1</sup> Засгийн газрын 2012 оны 106 дугаар тогтоол "Хоолны зардлын дундаж норматив батлах тухай" 1-т "Ерөнхий боловсролын сургуулийн 1-5 дугаар ангийн нэг хүүхдийн үдийн цайны өдрийн зардлыг 2013 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн 600 (зургаан зуун) төгрөгөөр, ерөнхий боловсролын тусгай сургуулийн суралцагчийн үдийн хоолны өдрийн зардлыг 2400 (хоёр мянга дөрвөн зуун) төгрөгөөр тогтоосугай"

Дээрх 7 сумд үдийн цайны материалын үлдэгдлийг их хэмжээгээр нөөцөлсөн, 2019 онд нийт 23.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Арвайхээр сумын ЗДТГазар нь Үдийн цай нийлүүлэх ААН-ийг сонгон шалгаруулах тендерийг жил бүр зохион байгуулж иржээ. Тендерт шалгарсан ААН байгууллагатай сумын Засаг дарга гэрээ байгуулсан байна. 2016-2017 оны хичээлийн жилд 13 ААН гэрээ байгуулсан бол 2017-2018 оны хичээлийн жилд 7 ААН, 2018-2019 онд 4 ААН-тэй гэрээ байгуулан ажилласан байна.

Аймаг дахь Төрийн аудитын газраас 2018 онд Аймгийн ерөнхий боловсролын сургуулиудын 2017 оны үдийн цай хөтөлбөрийн хэрэгжилтэд нийцлийн аудит хийж аудитын хүрээнд 16 сургуулийг хамруулсан байна. Аудитаар нийт 16 зөвлөмж өгсөн байна.

ЕБС-ийн хүүхдийн ирцийн тоонд үндэслэн үдийн цай хөтөлбөрийн зардлыг бодитоор тооцох үндэслэл болох тул багшийн журналыг бүрэн хөтлөх шаардлагатай байна.

- Гадаадын зээл, тусламжийн санхүүжилтээр хэрэгжсэн төсөл, хөтөлбөрийн санхүүжилт зориулалтын дагуу зарцуулагдсан байна.

БСШУС-ын 2017 оны А/208 дугаар, 2019 оны А/284 дугаар бүхий Сургуулийн тэтгэлэгт хөтөлбөрийг санхүүжүүлэх тухай тушаалаар “Боловсролын чанарын шинэчлэл” төслийн хүрээнд:

Хүснэгт 9 /сая.төг/

Д/д	Сургуулийн тэтгэлэгт хөтөлбөр хэрэгжүүлсэн он	Сургуулийн тоо	Төсөл хөтөлбөрийн тоо	Авсан санхүүжилт
1	2015-2016	11	11	63.3
2	2017-2018	23	23	149.8
3	2019-2020	15	19	324.4
	Нийт дүн	49	53	537.4

Нийтдээ 537.5 сая төгрөгийн төслийг хэрэгжүүлснийг аудитын явцад газар дээр нь үзэхэд төсөл бүрэн хэрэгжиж дууссан, хөтөлбөрийн санхүүжилт зориулалтын дагуу зарцуулагдсан байна.

Бид сурагч боллоо төслийн хэрэгжилтийн зураг.

Зураг 1





- *Сургууль хөгжүүлэх санг байгуулаагүй байна.*

БСШУСайд, Сангийн сайдын хамтарсан 2008 оны 56/64 дугаар тушаалын хавсралтаар Сургууль, цэцэрлэг хөгжүүлэх сангийн үлгэрчилсэн дүрэм гаргаж баталсан боловч аймгийн хэмжээнд сургууль хөгжүүлэх сан байхгүй байна.

## **БҮЛЭГ 2. Ерөнхий боловсрол олгох үйлчилгээний зорилго, зорилтын хэрэгжилт хангагдаж байгаа ч үйл ажиллагаанд тавих хяналт хангалтгүй байна.**

### **Б.1 Ерөнхий боловсролыг хөтөлбөрийн дагуу олгож байгаа боловч, сургалтын чанарын үнэлгээг бодитой хийгээгүй байна.**

#### **Б.1.1 Хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу бүх нийтийн ерөнхий боловсролыг эзэмшүүлж байна.**

- *Эзэмшвэл зохих боловсрол, ур чадварыг бүрэн олгож байна.*

Аудитад БСУГазар болон ерөнхий боловсролын 17 сургууль хамрагдсанаас гүнзгийрүүлсэн сургалттай 1, лаборатори 1 сургууль байна.

Аудитад хамрагдсан 17 сургуулийн хэмжээнд бага ангийн сургалтын менежер сэдвийг боловсруулан 1-5 ангид нэг хичээлийн жилд 2-4 удаагийн хөндлөнгийн шалтгалтыг авч матрицаас ахицын үнэлгээ гарган ажилласан байна. Хөндлөнгийн шалгалтын аймгийн дундаж 2016-2017 оны хичээлийн жилд 65.1 хувь, 2017-2018 оны хичээлийн жилд 62.0 хувь, 2018-2019 оны хичээлийн жилд 65.5 хувьтай байгаа бол Улсын шалгалтын аймгийн дундаж 2016-2017 хичээлийн жилд 73.0 хувь, 2017-2018 оны хичээлийн жилд 74.2 хувь, 2018-2019 оны хичээлийн жилд 75.0 хувьтай гарсан байна. Эндээс харахад Улсын шалгалтын дүн хөндлөнгийн шалгалтын дүнгийн зөрүү ойролцоо гарсан байгаа нь шалгалт бодитой дүгнэгдсэн гэж үзэхээр байна.

Дунд болон ахлах бүлгийн сурагчдад эзэмшвэл зохих онолын мэдлэг, сурах арга барил, асуудлыг шийдвэрлэх оновчтой арга, харьцуулах, нэгтгэн дүгнэх чадварыг сургалтын төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу олгож байна. Гэхдээ сурагчдын идэвх санаачилгатай байдал болон бага ангийн суурь мэдлэгийн түвшин зэргээс шалтгаалан анги дэвшигчдийн чанар тогтворгүй байдаг байна. Бага боловсролыг эзэмшүүлэх зохицуулалт нь зөвхөн 1 багшаар хэрэгждэг бөгөөд дунд ангиас эхлэн мэргэжлийн хичээлүүдийг дагнасан багш заах нь сурагчдын сурлагын чанарт нөлөөлдөг байна.

Аймаг болон лаборатори сургуулийн дундаж үнэлгээг хүснэгтээр харуулбал: Хүснэгт 10


		Сургуулийн дундаж сүүлийн 3 жилийн дунджаар			
		Дунд ангийн хөндөнгийн үнэлгээ	Дунд ангийн анги дэвших шалгалтын үнэлгээ	Ахлах ангийн хөндөнгийн үнэлгээ	Ахлах ангийн улсын шалгалтын үнэлгээ
Аймгийн дундаж		58.1	71.1	58.8	73.8
Үүнээс	Лаборатори Мэргэд сургууль	70.2	81.8	66.2	88.0

Дээрх хүснэгт дэх аймгийн нийт сургуулийн дунд болон ахлах ангийн дундаж үнэлгээний үзүүлэлтэд лаборатори Мэргэд сургуулийн сурагчдын үнэлгээ хамрагдсан болно. Мөн лаборатори Мэргэд сургуулийн дунд, ахлах ангийн сурагчдын дундаж үнэлгээг онцолж харууллаа.

Аймгийн бүх хөндлөнгийн шалгалтын дундаж үнэлгээ 58.5 хувь, анги дэвших болон улсын шалгалт 72.5 хувьтай байна. Үүнээс лаборатори Мэргэд сургуулийн хөндлөнгийн шалгалтын дундаж үнэлгээ 68.2 хувь, анги дэвших болон улсын шалгалт 84.9 хувьтай байна. Ахлах ангийн улсын шалгалтын дүн нь сурагчийн гэрчилгээнд бичигддэг тул зохих хэмжээгээр нэмэгддэг байна.


Аймгийн хэмжээнд Улсын төрөлжсөн олимпиадын 2-ын давааг зохион байгуулж, төрөлжсөн олимпиадаас шалгарсан багш, сурагчид улсын олимпиадын 3-ын даваанд амжилттай оролцож иржээ. 2016 онд 6 медаль, 2017 онд 4 медаль, 2018 онд 8 медаль, 2019 онд 5 медаль хүртсэн амжилт үзүүлсэн байна.

Дүрслэл 3



Аймгийн ЭЕШ-ийн дундаж оноог харуулбал

Дүрслэл 4




ЕБ-ын лаборатори Мэргэд сургууль нь 2013 оноос Үндэсний лаборатори сургуулиар сонгогдон боловсролын шинэчлэлийг турших, түгээн дэлгэрүүлэх ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулж, амжилттай ажиллаж байна. 2016-2019 онд буюу сүүлийн 3 хичээлийн жилд дундажаар 30 бүлэг 1060 сурагч суралцсан байна. Сургалтын орчин :

Хүснэгт 11

2020 он	Тоо	Хүчин чадал
Хичээлийн байр	3	960
Анги	29	30-35
Кабинет	17	20-35
Урлаг заал	1	100
Спорт заал	2	100
Номын сан	1	20
Уншлагын танхим	1	24
Цайны газар	1	40-50
Багшийн хөгжлийн төв	2	36
Хүүхдийн хөгжлийн төв	1	25-30

Аудитын хамрагдсан онуудад сургалтын чанарыг харуулбал:

Дүрслэл 5




Хичээлийн жилийн дундаж үнэлгээ нь 2016 оноос 2019 он хүртэл тогтмол ахисан үзүүлэлттэй байна.

Дүрслэл 6




Тус сургуулийн сургалтын чанарыг төрөлжсөн олимпиадад оролцсон амжилтаас харахад эзэлсэн байр он онд нэмэгдсэн байна.

Дүрслэл 7



Дүрслэл 8



Аудитад хамрагдсан сүүлийн 3 жилийн дунджаар аймгийн дундаж оноо 519.6, лаборатори Мэргэд сургуулийн дундаж оноо 609.6 байгаа нь лаборатори сургууль нь аймгийн сургуулиудын сургалтын чанараас дээгүүр байна.

Сургуулиуд нь нэмэлт сурах бичиг, гарын авлага ашиглахгүй байна.

**Б.1.2 Ерөнхий боловсролын сургалтын чанарын үнэлгээг бодитой гаргасан боловч бүрэн хамруулж чадаагүй байна.**

- *ЕБ-ын чанарын үнэлгээний судалгааг бодитоор гаргасан боловч, бүрэн хамруулж чадахгүй байна.*

Боловсролын үнэлгээний төвөөс 2016-2017 оны хичээлийн жилд аймгийн хэмжээнд 3 сургуулийн 5, 9, 12 дугаар ангийн сурагчдаас шалгалт зохион байгуулж дүгнэсэн байна. Чанарын үнэлгээний дүнгээс харахад шалгагдсан нийт сурагчдын дундаж улсын дунджаас дээгүүр дүгнэгдсэн байна. Харин 2018 оноос бүх сургуулийн 9 дүгээр ангийн сурагчдаас чанарын үнэлгээний судалгааг авдаг болсон бөгөөд 2018-2019 оны хичээлийн жилд 26 сургуулийн 9 дүгээр ангийн сурагчид, 3 сургуулийн 3, 10 дугаар ангийн сурагчдаас чанарын үнэлгээний дүн буюу судалгааг авахад улсын дунджаас дээгүүр үнэлэгдсэн байна.

- *Сургалтын чанарт сөргөөр нөлөөлөх хүчин зүйлсийн судалгаа авч бодитоор үнэлээгүй байна.*

Аймгийн БСУГазар болон ЕБС-ууд нь сургалтын чанарт сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлсийг үнэлсэн судалгаа, шинжилгээ хийгээгүй байна. Аудитын явцад тус асуудлыг сургуулийн захирал, сургалтын менежерүүдтэй ярилцлага хийж, сургалтын чанарт сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлж дүгнэлт хийлээ. Үүнийг дурдвал:

- Эцэг эхийн хандлага, үүрэг оролцоо хангалтгүй
- Багшийн мэдлэг ур чадвар дутмаг
- Сургуулиудын сургалтын дотоод орчин хангалтгүй
- Багшаар төгссөж байгаа багш нарын мэдлэг, ур чадвар сул
- Айл өрхийн амьжиргааны түвшин, ажилгүйдэл
- Гэр бүл салалт

- Багш нар үндсэн ажлаас гадна олон нийтийн ажлууд
- Багш нар сум орон нутагт тогтвор суурьшилтай ажилладаггүй
- Төвийн сургуулиудад хүүхдийн тоо их, анги дүүргэлт өндөр
- Шаардлага хангасан кабинет, лаборатори, дадлага, туршилтын талбайгүй, сургалтын багаж, тоног төхөөрөмж, техник хэрэгсэл хангалтгүй
- Цахим орчин, гар утасны хэрэглээ өндөр
- Салбарын яамны үйл ажиллагаа тогтвортой бус байдлаас болж хичээлийн жилийн бүтэц, сургалтын хөтөлбөр өөрчлөгддөг
- Хичээл практик, ном хэвлэлийн зардал бага зэрэг хүчин зүйлсүүлд нөлөөлж байгаа гэсэн байна.

**Б.2 Бүх нийтийн ерөнхий боловсрол олгох үйлчилгээнд тавих хяналт үр нөлөөгүй, хэрэгжилт хангалтгүй, үр дүнг тооцоогүй байна.**

**Б.2.1 Ерөнхий боловсрол олгох үйлчилгээнд тавих үе шатны хяналт хангалтгүй, үр дүнг тооцож ажиллаагүй байна.**

- *Салбарын яамны хяналт хийгдээгүй байна.*

Аудитад хамрагдсан 2016-2019 он буюу 3 хичээлийн жилд БСУГ-т салбар яамнаас хяналт, шалгалт хийгдээгүй байна.

- *Салбарын яамны зүгээс гадаадын зээл, тусламжийн санхүүжилтээр хэрэгжсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнг үнэлээгүй байна.*

БСШУС-ын яам нь 2015 оноос 2019 оны хооронд Дэлхийн банкны дэмжлэгтэй боловсролын салбарын шинэчлэлийн төслийг орон даяар бага сургуулийн чанарыг сайжруулах зорилтот төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлсэн байна.

Тус аймаг 2016 оноос уг хөтөлбөрт хамрагдаж, 2016-2019 онд ЕБ-ын 48 сургуульд 537.5 сая төгрөгийн 53 төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллажээ. Салбарын яамнаас төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд зөвлөн туслах үйл ажиллагааг зохион байгуулахыг аймгийн БСУГазарт чиглэл болгожээ. Иймд зөвлөн туслах багийн удирдамжийн дагуу тухайн сургуулиудад гүйцэтгэлд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээг газар дээр нь үзэж танилцан зөвлөмж өгч ажилласан байна.

БСШУС-ын яамнаас хөтөлбөрийг санхүүжүүлэх гэрээг БСУГ-тай байгуулж, тус гэрээний 2.1.2-т “үйл ажиллагааны таван чиглэлээр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнг тооцно” гэж заасан байхад тус яамнаас хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнг тооцоогүй байна.

- *Орон нутгийн боловсролын газрын хяналт хангалтгүй, үр нөлөөгүй байна.*

Боловсролын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28<sup>1</sup>.1.4<sup>1</sup>-т зааснаар БСУГ-аас 2016-2019 онуудад нийт 24 удаа 16 хүний бүрэлдэхүүнтэй сургууль тус бүр дээр хоёр хоногийн хугацаатай ажилласан боловч зөвлөн туслах үйл ажиллагааны үр дүнг тооцоогүй байна.

Аудитад хамрагдсан 17 сургуулиудад БСУГ-аас зөвлөн туслахаар ажилласан дүнгийн хурлын тэмдэглэлд тухайн сургуулийн илэрсэн зөрчил, дутагдал нь тодорхойгүй, зөрчлийг арилгасан талаар тайланг хүлээж авдаггүй бөгөөд үүний улмаас биелэлт болон ажил сайжруулсан тайланг шалгах боломжгүй байна. Илэрсэн зөрчил тодорхойгүй учраас тухайн сургуулиудын үйл ажиллагааны зөрчил давтагдсан, цаашид гарсаар байх эрсдэл өндөр байна.

<sup>1</sup> Боловсролын тухай хуулийн 28-р зүйлийн 28<sup>1</sup>.1.4-т “Боловсролын байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих, хяналт-шинжилгээ хийх”



БСУГ-ын 2016-2019 онд сургуулиудын багш, сурагчдаас авсан мэргэжлийн онолын шалгалт болон стандарт хангалтын дүнг он тус бүрээр нэгтгэж дүгнэхэд, мэргэжлийн онолын шалгалтын дундаж 63.7%, стандарт хангалт 54.2%-тай шалгагдсан байна. Бага ангийн стандарт хангалт болон мэргэжлийн онолын шалгалтын дүнг 2017, 2018, 2019 онуудад дунд ангийн стандарт хангалт мэргэжлийн онолын шалгалтын дүнтэй харьцуулалтын аргаар дүгнэхэд ахисан үзүүлэлттэй байгаа нь БСУГ-ын бага боловсрол хариуцсан мэргэжилтэн нь сургалтын менежер болон багшид өгөх арга зүйн зөвлөгөөг оновчтой өгч, багшийг чадавхжуулах, хөгжүүлэх, ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр үр дүнтэй ажилласан нь дараах хүснэгтээс харагдаж байна.

Хүснэгт 12

№	Сургуулийн нэр	Мэргэжлийн онолын дүн								Дундаж	Стандарт хангалтын дүн								Дундаж	
		Дунд анги				Бага анги					Дунд анги				Бага анги					
		2016	2017	2018	2019	2016	2017	2018	2019		2016	2017	2018	2019	2016	2017	2018	2019		
1	Бат-Өлзий ЕБС				67.4				72.6	70.0					59.7				70.7	65.2
2	Баруунбаян-Улаан ЕБС				65.8				71.7	68.7					43.6				44.6	44.1
3	Гучин-Ус ЕБС		59.6					26.4		43.0		45.0				39.8				42.4
4	Хайрхандулаан ЕБС				70.8				73.8	72.3					45.9				57.8	51.9
5	Нарийнтээл ЕБС				61.8				70.0	65.9					42.3				63.8	53.1
6	Төгрөг ЕБС		66.6					49.7		58.2		46.0				30.4				38.2
7	Богд ЕБС			61.7					42.9	52.3			43.4				47.9			45.7
8	Уянга ЕБС-1			65.6					42.5	54.1			60.6				52.4			56.5
9	Уянга ЕБС-2			66.0					51.1	58.6			54.3				60.2			57.3
10	Хужирт ЕБС	+			69.7	+			78.8	74.3	+			51.3	+				65.0	58.2
11	Хархорин ЕБС-1	+				+					+									
12	Хархорин ЕБС-2	+				+					+									
13	Хархорин ЕБС-Гүнзгий	+				+					+									
14	Арвайхээр ЕБС-1								+											
15	Арвайхээр ЕБС-2																			
16	Арвайхээр ЕБС-Мэргэд				72.1				84.0	78.1				74.7					86.5	80.6
17	Арвайхээр ЕБС-4				68.1				71.0	69.5				61.3					53.2	57.3
	Дундаж		63.1	64.4	68.0		38.1	45.5	74.6	63.7		45.5	52.8	45.4		35.1	53.5	55.5		54.2

БСУГ-ын мэргэжлийн арга зүйч нар нь багш хөгжлийн цахим кампус мэдээллийн системийг ашиглан нийт багш нараас мэргэжлийн шалгалтыг авч байна.

- *Байгууллагын түвшинд дотоод хяналт хэрэгжиж байгаа боловч үйл ажиллагаа бүрэн төлөвшөөгүй байна.*

ЕБС-ууд дотоод хяналтын журмын дагуу төлөвлөгөө боловсруулж ажиллаж байгаа боловч хэрэгжилт хангалтгүй, байгууллагынхаа онцлогт тохируулан боловсруулаагүй байна.

Дотоод хяналтын нэгжийн улирал бүр гаргасан тайлантай танилцахад хяналт шалгалтын ажлын дүн, авсан арга хэмжээний талаар тайланд тусгагдаагүй, илэрсэн

зөрчил, дутагдлын талаар хамт олны хурлаар болон удирдах зөвлөлөөр хэлэлцүүлээгүй, дотоод хяналтын нэгж, ажилтан эрх үүргээ төдийлөн сайн мэдэхгүй, хийсэн хяналт шалгалтын талаар бүртгэл хөтөлж, мэдээллийн сан бүрдүүлээгүй, мэргэжлийн байгууллагаас зөвлөгөө сургалт авдаггүй, дотоод хяналт шалгалт зохион байгуулах журмын зорилготой уялдаагүй байна.

Зарим сургууль нь дотоод хяналтын нэгжийн гаргадаг дотоод хяналт хийсэн талаарх тайлан бус байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл оруулсан байна. ЕБ-ын сургуулиудын дотоод хяналтын нэгжийн гишүүдтэй үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд гарч буй хүндрэл, бэрхшээлийн талаар ярилцлага хийхэд:

- Үндсэн ажлын ачаалал ихтэй байдгаас төдийлөн сайн хяналт хийж чаддаггүй.
- Урамшуулал олгогддоггүй
- Санхүүгийн мэдлэг дутмагаас төлөвлөгөөнд тусгагдсан санхүүгийн үйл ажиллагааны хяналтыг чанартай гүйцэтгэж чаддаггүй
- Зарим ёс зүйгүй багш, ажилчдад хэл амаар доромжлуулж өстөн болдог
- Төсөв хөрөнгө дутмагаас зөрчил, дутагдлаа арилгаж чаддаггүй зэрэг асуудлууд дурдагдаж байна.

Эдгээрээс үзэхэд ЕБ-ын сургуулиудын дотоод хяналтын хэрэгжилт хангалтгүй байна.

- *Хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ үнэлгээ хийж үр дүнг тооцоогүй байна.*

Сургуулиудын хөтөлбөрийн хэрэгжилтэд аймгийн Засаг даргын Тамгын газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний баг тухайн сумын жилийн ажлыг дүгнэх ажлын хүрээнд үнэлж дүгнэж байна. Яамны болон хөндлөнгийн байгууллагаас хөтөлбөрийн хэрэгжилтэд үнэлгээ хийж үр дүнг тооцож дүгнээгүй байна.

- *Сургалтын хөтөлбөрт тавих шат шатны хяналт нь төдийлөн үр дүнтэй хэрэгжээгүй байна.*

Сургуулиудад сургалтын хөтөлбөрийг цөм хөтөлбөр болон боловсролын стандартад үндэслэн багш нар боловсруулж сургалтын менежер батлан сургалтыг зохион байгуулж байна. Сургалтын менежер нь багш нарын хичээлд суух хуваарь гарган багшийн заах арга зүйд хяналт тавьж ажиллаж байгаа боловч сургалтын хөтөлбөрт тавих хяналт дутагдалтай байна.

БСУГ-аас удирдамжийн дагуу жил бүр зөвлөн туслах үйл ажиллагааг зохион байгуулж ажиллахдаа багш нарын хичээлд суух, сургалтын төлөвлөгөө хөтөлбөр, хичээлийн бэлтгэлийн байдалтай танилцан хяналт хийж ажилласан байна.

### ***Б.2.2 ЕБ олгох үйл ажиллагаанд тавих хөндлөнгийн хяналтын хэрэгжилт хангалтгүй байна.***

- *Мэргэжлийн байгууллагуудын зүгээс хийгдсэн хяналтын хэрэгжилт хангалтгүй байна.*

Мэргэжлийн хяналтын газрын зүгээс 3 хичээлийн жилд нийт 24 удаагийн хяналт шалгалтаар 54 зөвлөмж, 259 албан шаардлага хүргүүлсэн байна. Аудитын явцад зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилт болон үр дүнг шалгахад биелэлт хангалтгүй байна.

Мэргэжлийн хяналтын газрын хяналт шалгалтаар илэрсэн зөрчлүүдээс дурьдвал:

- ✓ Физик, Хими, Дуу хөгжим, Гадаад хэл, Биологи, Технологийн хичээлүүдийн сургалтын орчныг стандартын түвшинд биелүүлээгүй, сургалтын тоног төхөөрөмж, хэрэглэгдэхүүн, техник хэрэгсэл хангалтгүй

- ✓ Ахлах ангиудын Орос хэл, Газар зүй, Биологи, Физик, Англи хэлний хичээлүүдийн стандарт хангалт хангалтгүй
- ✓ Багш нарын цагийн ачаалал 19 цагаас илүү
- ✓ Дотоод хяналт шалгалтын үйл ажиллагааг бүрэн төлөвшүүлээгүй
- ✓ Сургалтын менежер нь сургалтын явцад хийгдэх лаборатори, дадлага ажлыг батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу зохион байгуулдаггүй, дадлага, туршилт хийх орчныг бүрдүүлээгүй
- ✓ Багш хөгжлийн төвийн үйл ажиллагааг чанартай зохион байгуулж, төсөв санхүүгийн дэмжлэг үзүүлэн ажиллаагүй
- ✓ Номын сан нь номын сангийн үйлчилгээний стандартын түвшинд хүргээгүй зэрэг зөрчлүүд нь удаа дараа давтагдаж гарсаар байна.
- *Эцэг эх, олон нийтийн зүгээс тавих хяналт, үүрэг оролцоо хангалтагүй, үр дүнгүй байна.*

Ерөнхий боловсролын сургуулиуд эцэг эх, олон нийтийн үүрэг оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр төлөвлөгөө боловсруулан ажиллаж байгаа боловч дараах дутагдалтай талууд байна. Үүнд:

- Эцэг, эхтэй хийсэн ярилцлагын тэмдэглэл, дэлгэрэнгүй судалгаа байхгүй
- Эцэг, эхийг мэдээллээр хангах, хамтран ажиллах үйл ажиллагаа нэр төдий, үр дүнд хүрээгүй
- Анги удирдсан багш нь эцэг эхтэй ажиллах төлөвлөгөө гаргаж ажиллаагүй
- Эцэг эх болон сурагчдаас авсан судалгаа нэр төдий, дүгнэж хэрэгжүүлээгүй

Ерөнхий боловсролын сургуулиудын бага ангийн эцэг эхийн үүрэг оролцоо хангалттай сайн байдаг боловч дунд, ахлах ангид суларч байна. Олон нийтийн зүгээс тавих хяналт, үүрэг оролцоо хангалтгүй байна.

**Үндэсний Аудитын газрын харьяа  
Өвөрхангай аймаг дахь Төрийн Аудитын газар**



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА  
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН  
ТУШААЛ

2020 оны 10 сарын 29 өдөр

Дугаар А/17

Арвайхээр

Гүйцэтгэлийн аудитын тайланг  
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 9 дүгээр зүйлийн 9.1, 20 дугаар зүйлийн 20.1, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/207 дугаар тушаалаар батлагдсан "Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторт шилжүүлэх эрх, үүрэг"-ийн 5 дугаар хавсралтын 2.4 дэх заалт, мөн 2016 оны А/92 дугаар тушаалаар батлагдсан "Гүйцэтгэлийн аудитын журам"-ын 12.40 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсрол олгож буй өнөөгийн байдал, үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан /ӨВА-2020/10-ГА/-г баталгаажуулсугай.

2. Аудитаар өгөгдсөн акт, албан шаардлагын жагсаалтыг хавсралтаар баталсугай.


3. "Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсрол олгож буй өнөөгийн байдал, үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газар, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга /О.Пүрэвдорж/, аймгийн Засаг даргын орлогч /О.Батжаргал/, Засаг даргын дэргэдэх Боловсрол, соёл, урлагийн газрын дарга /Ж.Пүрэвсүрэн/-д тус тус хүргүүлсүгэй.

4. Аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг 2020 оны 12 дугаар сарын 10-ны дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Засаг даргын дэргэдэх Боловсрол, соёл, урлагийн газрын дарга /Ж.Пүрэвсүрэн/-д зөвлөсүгэй.

5. Аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг аудитын менежер /Д.Гансүх/, аудитор /С.Шийлэгмаа/ нарт даалгасугай.

ДАРГА БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Л.ЛАМААЧИН



015010001

**Холбогдох байгууллагын санал:**

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ  
БОЛОВСРОЛ, СОЁЛ, УРЛАГИЙН  
ГАЗАР**

62173 Арвайхээр, Өвөрхангай аймаг,  
Утас/Факс: (976) 7032 2506,  
E-mail: uvurkhangai@mecs.gov.mn

2020.10.29 № 241  
танай 2020.10.28-ны № 417 -Т

**ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ**

Монгол улсын Ерөнхий аудиторын 2019 оны “Аудитын төлөвлөгөө батлах тухай” А/100 дугаар тушаалаар батлагдсан төлөвлөгөө, удирдамжийн дагуу “Бүх нийтийн ерөнхий боловсрол олгож буй өнөөгийн байдал, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлантай танилцлаа.

Тайлантай холбогдуулан хүргүүлэх саналгүй байна.



ДАРГА

Ж.ПҮРЭВСҮРЭН

751300283

D:/Bichig hereg/2020 on/a5.

**Саналд өгсөн тайлбар:**

Ирүүлсэн санал, баримт материалд үндэслэн дараах тайлбарыг өгч байна.

## **ДҮГНЭЛТ:**

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

**БҮЛЭГ 1. Ерөнхий боловсрол олгож буй өнөөгийн нөхцөл хэрэгцээ шаардлагад нийцэж байна.**

**А.1 Хууль тогтоомж эрх зүйн зохицуулалт, бодлого, хөтөлбөр хэрэгцээ шаардлагыг хангасан байна.**

А.1.1 Мөрдөж буй хууль, дүрэм журам, хэрэгцээ шаардлагыг хангаж, харилцан уялдаатай байгаа ч зарим зохицуулалт давхардаж байна.

А.1.2 Салбарын яамны бодлого хөтөлбөртэй орон нутгийн зарим дэд хөтөлбөрүүдийн агуулга давхардсан байна.

**А.2 Сургалтын хэрэгцээ шаардлагыг бүрэн хангасан мэргэжлийн боловсон хүчин бүрэн хангагдсан, хүртээмжтэй материаллаг орчныг бүрдүүлсэн байна.**

А.2.1 Хамран сургалтын тэгш, хүртээмжтэй орчныг бүрдүүлсэн байна.

А.2.2 Ерөнхий боловсролыг олгоход шаардагдах хэвийн, аюулгүй материаллаг орчин, нөхцөл бүрдсэн байна.

А.2.3 Зарим боловсон хүчний мэргэжлийн мэдлэг хангалтгүй, хими, математик, эрэгтэй технологи, дуу хөгжмийн багшийн эрэлт хэрэгцээ их байна.

**А.3 Ерөнхий боловсролын үйл ажиллагааны санхүүжилт бодитой төлөвлөгдөн ихэнх зардлыг зориулалтын дагуу зарцуулж байна.**

А.3.1 Төсвийг бодитой төлөвлөж, хүүхдийн тоотой уялдуулан хуваарилсан байна.

А.3.2 Санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулж байгаа боловч үдийн цай хөтөлбөрийн зарцуулалтад тавих хяналт хангалтгүй байна.

**БҮЛЭГ 2. Ерөнхий боловсрол олгох үйлчилгээний зорилго, зорилтын хэрэгжилт хангагдаж байгаа ч үйл ажиллагаанд тавих хяналт хангалтгүй байна.**

**Б.1 Ерөнхий боловсролыг хөтөлбөрийн дагуу олгож байгаа боловч, сургалтын чанарын үнэлгээг бодитой хийгээгүй байна.**

Б.1.1 Хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу бүх нийтийн ерөнхий боловсролыг эзэмшүүлж байна.

Б.1.2 Ерөнхий боловсролын сургалтын чанарын үнэлгээг бодитой гаргасан боловч бүрэн хамруулж чадахгүй байна.

**Б.2 Бүх нийтийн ерөнхий боловсрол олгох үйлчилгээнд тавих хяналтын хэрэгжилт хангалтгүй, үр дүнг тооцоогүй байна.**

Б.2.1 Ерөнхий боловсрол олгох үйлчилгээнд тавих үе шатны хяналт хангалтгүй, үр дүнг тооцож ажиллаагүй байна.

Б.2.2 ЕБ олгох үйл ажиллагаанд тавих хөндлөнгийн хяналтын хэрэгжилт хангалтгүй байна.

## **ЗӨВЛӨМЖ:**

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.Үүнд:

БСУГ-ын дарга Ж.Пүрэвсүрэнд

1. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнгийн биелэлтийг тооцож ажиллах
2. Гадаадын зээл, тусламжийн санхүүжилтээр хэрэгжсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж үр дүнг тооцож ажиллах
3. Дотоод хяналт хийхэд холбогдох эрх зүйн орчныг бүрдүүлэх, мэргэжилтнүүдийг сургах, давтан сургах арга хэмжээг авч хэрэгжүүлэх
4. Сургалтын чанарт сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлсийн судалгааг бодитой үнэлэн байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган ажиллах

ЕБС-ийн захирал, сургалтын менежер, нягтлан бодогч нарт

1. Сурагчдын оношлох шалгалт, хөндлөнгийн шалгалт, анги дэвших болон улсын шалгалтын дүнг харьцуулан тухайн жилийн сурагчдын ахицыг бодитоор тооцож байх
2. Шалгалтын дундаж гүйцэтгэлийг харьцуулан хоцрогдолтой сурагчдын хоцрогдлыг арилгаж ажиллах
3. Багшийг ажлын байранд хөгжүүлэх ажлыг үр дүнтэйгээр тасралтгүй зохион байгуулах
4. Багш, ажиллагсдын хувийн хэргийг журамд заасны дагуу бүрэн бүрдүүлэх
5. Багш нарын журнал дээрх сурагчдын ирцийн бүртгэлийг үнэн зөв хөтлүүлж, жижүүрийн дэвтрийн тэмдэглэл дээрх анги бүрээс авсан сурагчдын өдөр тутмын ирцийн бүртгэл, үдийн цай нийлүүлэгч байгууллагын нэхэмжлэх болон тогоочийн хүүхдийн тоотой тулган шалгаж санхүүжилтийг хүүхдийн ирцийн бүртгэлд үндэслэн тухай өдрийн гүйцэтгэлээр тооцож олгож байх.
6. Үдийн цай хөтөлбөрийн санхүүжилтээс хэмнэгдсэн мөнгөний үлдэгдлийг төсөвт буцаан төвлөрүүлж, бараа материалын үлдэгдлээр бүртгэхгүй байх.
7. Байрны хүүхдийн ирцийн журналтай болгох, хүүхдийн ирцийн журналыг тогоочийн шаардах хуудасны хүүхдийн тоотой тулган шалгаж тухайн өдрийн хүнсний материалыг олгож байх.
8. Хүнсний хэт их хэмжээгээр нөөцлөхгүй байх.

**Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газарт санал хүргүүлэх нь:**

1. Багш бэлтгэх тогтолцоог сайжруулах, хос мэргэжлээр төгсгөх боломжийг бүрдүүлэх
2. Багшийн хөгжлийн дэмжих тухай хуулийн дагуу Багшийн хөгжлийн төвийн үйл ажиллагаанд ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагын нийт хувьсах зардлын хоёр хувь хүртэл хэмжээний зардлыг зарцуулах эрх зүйн орчин бүрдүүлэх, төсөвт суулгах



## **ХАВСРАЛТУУД:**

*Хавсралт 1.*
